

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар

2022 оны жилийн эцэс

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
МУ-ын хууль							
1	1	Ойн тухай /Шинэчилсэн найруулга/ 2012-05-17 Дугаар 2022.06.03	39.7. Ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, сум, нийслэл, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгана.	Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын дагуу урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй буюу гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд аймгийн болон сумдын Засаг даргын нөөц хөрөнгөд нийт 1,0 тэрбум төгрөг төлөвлөн тусгасан байна.	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх
2	2	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	18.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Монгол улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал “Алсын хараа-2050”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан гэр бүлийн гишүүдийн өмнө тулгамдаж буй хэрэгцээ шаардлагад чиглэсэн олон талт үйлчилгээг оновчтой зохион байгуулж, эцэг эхийн үүрэг хариуцлага, нийгмийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх зорилготой "Монгол гэр бүл" хөтөлбөрийг 5 зорилтын хүрээнд боловсруулж аймгийн Иргэдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 83 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Залуу гэр бүлийн хөгжлийг дэмжих, соён гэгээрүүлэх, чадавхжуулах “Залуучуудын хөгжил” дэд хөтөлбөрийг аймгийн	70%	70%	

				Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлж байна.			
	3		18.1.2.. Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, гэр бүлийн хохирогч насанд хүрэгч, хүүхдэд шаардлагатай тусламж үйлчилгээ, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байрны хэвийн үйл ажиллагааг хангах зардалд 80.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгуулж, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн дүгнэлээ. 2022 онд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажилд 17 сумын 29 хамтарсан багт 8.7 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн байна.	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх
	4		18.1.3.. Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Ховд аймгийн ГБХЗХГ-ын дэргэд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч насанд хүрэгч, хүүхдэд шаардлагатай тусламж үйлчилгээ, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байрыг 698 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 оны 11 сард ашиглалтанд оруулж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Тус хамгаалах байр нь Зохицуулагч 1, сэтгэлзүйч 1, нийгмийн ажилтан 3, туслах ажилтан 2, нярав 1, жижүүр 3, үйлчлэгч 1 гэсэн 12 ажилтны орон тоотой ажиллаж, хүчирхийллийн хохирогч хүүхэд эмэгтэйчүүдэд нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, боловсролын үйлчилгээнүүдийг үзүүлж байна. Мөн БОЭТ-ийн 103 яаралтай тусламжийн их эмч гэрээгээр ажиллаж, эрүүл мэндийн шйлчилгээ үзүүлдэг болно. 2022 онд Түр хамгаалах байр нь хүчирхийллийн хохирогч нийт 45 үйлчлүүлэгч хүлээн авч шаардлагатай	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх

			хариу үйлчилгээг үзүүлж, тасралтгүйгээр хэвийн ажиллалаа. Үүнээс насанд хүрэгч 7, хүүхэд 38 үйлчлүүлсэн бөгөөд нийт үйлчлүүлэгчдийн 83,3% нь хүүхэд юм. 2022 онд НҮСХАС-аас 30 сая, Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банктэй хамтран Японы сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй "Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх" төслөөс 15 сая төгрөгийн дэмжлэг авч, үйлчлүүлэгчийн ая тухтай байрлах орчин нөхцөлийг хангасан байна.			
5		19.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлж, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд чиглэсэн 10 төрлийн сургалт, нөлөөллийн 4 үйл ажиллагааг зохион байгууллаа. "Family Open mic арга хэмжээ", "Гэр бүлийн үнэ цэнэ", "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга", "Бүх хайраа гэр бүлдээ", "Уураар биш ухаанаар хүмүүжүүлэе", "Ханьсан амьдрахын утга учир" "Гэдэстэй-аав", "Гэр бүлийн зөрчил маргааныг эергээр шийдвэрлэх нь" сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 18000 гаруй иргэнийг хамруулсан байна. Дээрх сургалт, нөлөөллийн ажлаар дамжуулан гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн харилцааг сайжруулах, өрхийн төсөв санхүүгээ зөв зохицуулах, хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх болон архи тамхи хорт зуршлаас татгалзах донтолтоос сэргийлэх тухай ойлголт мэдлэгийг иргэдэд хүргэв. Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг 17 суманд зохион байгуулж, 25 сургуулийн 405 багш ажилчид, 3600 гаруй эцэг эхчүүд "Гэр бүл хүүхэд хамгааллын өнөөгийн байдал анхаарах асуудал", "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга", "Үе тэнгийн дарамт, цахим орчноос сэргийлэх нь" сэдэвт сургалтанд хамрагдаж	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх

				хүүхдийн нас бие, хөгжлийн онцлогт нийцүүлэн, эерэг аргаар хүмүүжүүлэх арга зүйг эзэмшсэн байна.			
	6		19.1.2.. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Сумдын Хамтарсан багийг арга зүйгээр хангах, хамгааллын хариу үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх үүднээс дараах арга хэмжээг авч ажиллалаа. Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн аймгийн нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж 200 гишүүдийг хамруулж чадваржуулсан бөгөөд сургалтын үр дүнд хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн хамтын ажиллагаагаа сайжирч, хүүхдийг асран хамгаалах анхдагч орчин болох гэр бүл, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлсэн байна. Гэр бүл, хүүхдийн чиглэлээр хэрэгжүүлж буй цахим программ дээр ажиллах чадварыг нэмэгдүүлэх, дадлагажуулах сургалтыг зохион байгуулж сум, багийн 29 хамтарсан багийн 44 нийгмийн ажилтан, аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 15 албан хаагчид хамрагдлаа. Тус сургалтад хамрагдсанаар Нийгмийн ажилтны мэдээллийн сан, e-tuslamj.mn, Хүүхдийн тусламжийн 108 утас программ, ABLE, nams программ, дээр ажиллах чадвар нэмэгдэж нийгмийн ажлын үйлчилгээ цахим программын ашиглалт сайжирсан байна.	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх
	7		19.1.3.. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны	Ховд аймгийн ГБХЗХГ-ын дэргэд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч насанд хүрэгч, хүүхдэд шаардлагатай тусламж үйлчилгээ, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байрыг 698 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 оны 11 сард ашиглалтанд оруулсан бөгөөд үйл ажиллагаагаа хэвийн зохион байгуулж байна.	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх

		Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)				
8		19.1.4.. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, гэр бүлийн хохирогч насанд хүрэгч, хүүхдэд шаардлагатай тусламж үйлчилгээ, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байрны хэвийн үйл ажиллагааг хангах зардалд 80.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгууллаа. Гэр бүлийн гишүүдийн өмнө тулгамдаж буй хэрэгцээ шаардлагад чиглэсэн олон талт үйлчилгээг оновчтой зохион байгуулж, эцэг эхийн үүрэг хариуцлага, нийгмийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх зорилготой "Монгол гэр бүл" хөтөлбөрийг 5 зорилтын хүрээнд боловсруулж аймгийн Иргэдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 83 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Залуу гэр бүлийн хөгжлийг дэмжих, соён гэгээрүүлэх, чадавхжуулах “Залуучуудын хөгжил” дэд хөтөлбөрийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлж байна.	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх
9		19.1.5.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Тус онд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог 4 удаа хуралдуулж, гэмт хэргийн хохирогч 9 хүүхэд, гэмт хэрэгт холбогдсон 4, эрсдэлт нөхцөлд амьдарч буй 3, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 2, нийт 18 хүүхдийн асуудлыг хэлэлцэж боловсрол, хууль зүй, сэтгэл зүй, эрүүл мэнд нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлсэн байна. Хүчирхийллийн хохирогч 8 хүүхдэд хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлж 6 хохирогч хүүхдэд орон нутгийн төсвөөс 6,5 сая төгрөг зарцуулж өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн байна. Ховд	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх

			аймаг дахь хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчид хандан 1 хохирогч хүүхдэд өмгөөллийн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлээ. Бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон 3 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажиллаж, 5 хохирогч хүүхдийг түр хамгаалах байранд байрлуулж хариу үйлчилгээ үзүүлээ.			
10		19.1.6.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:	Хохирогчид үйлчилгээ үзүүлэх, орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дараах үйл ажиллагаа төлөвлөн хийж гүйцэтгэлээ. Үүнд: НҮБ-ын Хүн амын сангийн 25 сая төгрөгийн тусламжаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор стандартад нийцсэн хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлснээр хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний чанар сайжирлаа. Хохирогчдыг нөхөн сэргээх, чадваржуулах үйлчилгээ үзүүлэх зорилгоор түр хамгаалах байранд сургалтын өрөөг тохижуулж, орчин нөхцөлийг бүрдүүлж хүүхэд, эцэг эхчүүдэд холбогдох сургалтуудыг төлөвлөн хүргэж байна. Кейс шийдвэрлэлтийн 4 өрөөг тохижуулан иргэдтэй ганцаарчилсан болон бүлгийн уулзалтыг зохион байгуулж, хамтарсан багийн гишүүд кейс тохиолдлын талаарх хурлыг зохион байгуулж хамтарсан багаараа 18 удаа хуралдаж үйл ажиллагаа нь тогтворжсон байна.	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх
11		19.1.7.. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй	Архины хамааралтай гэр бүлийн гишүүдэд нийгэм сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэх сургалт зохион байгуулж, амь нас эрүүл мэнд аюулгүй байдлыг хангах замаар гэр бүлийн тогтвортой байдлыг бий болгох, эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Тунгалаг буянт АА бүлэг”-тэй хамтран ажиллаж байна. Ховд аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, Ховд аймаг дах	70%	70%	

		тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Цагдаагийн газар хамтран 12 баг тус бүрээс архины хамааралтай тус бүр 1 иргэнийг сонгож АА-нийгэмлэгийн Ховд салбарын 5 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан сургалт нөлөөллийн арга хэмжээнд оролцуулж, хандлага сэтгэлгээг өөрчлөх чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгууллаа. Аймгийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас төслийн байгууллагатай хамтран хүүхэд хамгаалал, хүчирхийллийн эсрэг соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, нөлөөллийн арга хэмжээ авлаа. Мөн “Хөдөөний айл” төрийн бус байгууллагын тэргүүн Ч.Ерөөлтүвшинг урьж “Эрүүл амьдралын хэв маяг”, “Архины хор уршиг” сэдэвт лекцэд 150 иргэнийг хамруулав. “Архигүй бол зөрчилгүй” гэрэл зургийн уралдааныг зохион байгуулж эхний 3 байр шалгаруулж, гэрэл зургийн үзэсгэлэн гаргасан нийт 14 сургалт, 2 арга хэмжээнд 4152 иргэнийг хамрууллаа.			
12		19.1.8.. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Олон улсын гэр бүлийн өдрөөр “Бүх хайраа гэр бүлдээ” сэдэвт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж 20 гэр бүл 50 иргэдтэй гэр бүлийн үнэ цэнийн талаар ярилцаж ТВ контент бэлтгэн, 2000 иргэдэд хүргэж ажилласнаар гэр бүлийн үнэ цэнийн талаар мэдлэг хандлага дээшилсэн байна. Албан байгууллага аж ахуйн дэргэдэх 106 эцэг эхийн зөвлөл байгуулагдан ажиллаж байгаа ба гэр бүл, хүүхэд рүү чиглэсэн үйл ажиллагааг чанартай үр дүнтэй зохион байгуулан ажиллаж байна. 2022 оны шилдэг эцэг эхийн зөвлөл шалгаруулан урамшуулж, олон нийтэд сурталчлав. Харьалах нутаг дэвсгэртээ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийг сурталчлах,	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх

				хэрэгжүүлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлж, хүүхдийн тусламжийн 108 утас болон бичгээр ирсэн өргөдөл гомдолд хариу үйлчилгээг анхан шатанд чанар хүртээмжтэй үзүүлж байна. Ховд аймгийн Зэрэг сумын хамтарсан баг, Жаргалант сумын хамтарсан баг, Жаргалант сумын Бугат багийн хамтарсан багууд ажлын үзүүлэлтээр шалгарч, 2022 оны Ховд аймгийн "Шилдэг хамтарсан баг"-аар шалгарсан байна.			
	13		25.2.. Тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно.	2021 оноос эхлэн Ховд аймгийн Цагдаагийн газарт 1, Булган суман дах Сум дундын Цагдаагийн хэлтэст 1 нийт 2 хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн томилогдон ажиллаж байна.	100%	100%	
3	14	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг албан хаагчдаас сургалт, хөгжлийн үйл ажиллагаа, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах талаар судалгаа, санал асуулга авч нэгтгэн дүгнэж, боловсруулалт хийж ажиллав. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/131 дүгээр тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2.3-ын "а" дахь заалтын дагуу 23 албан хаагчдад цалинтай 5 хоногийн чөлөө, 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын дагуу 7 албан хаагчдад 1400000 мянган төгрөг, 8.1.3 дахь заалтын дагуу 13 албан хаагчдад 3100000 мянган төгрөг 8.1.4 дэх заалтын дагуу ажлын шаардлагаар өөр аймаг, хот руу гэр	100%	100%	

				бүлээрээ шилжин ажиллах болсон 2 ажилтанд тус бүр 300000 төгрөг, 8.1.7 дахь заалтын дагуу 36 албан хаагчдад түлшний үнийн хөнгөлөлт 3600000 төгрөг, 8.1.9 дахь заалтын дагуу шинэ хүүхэд мэндэлсэн 6 албан хаагчдад 600,000 төгрөгний тус тус буцалтгүй тусламжийг үзүүллээ. Аймагт үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бүх байгууллагууд нь Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг тооцон ажиллаж байгаа ба сум, байгууллагуудын үйл ажиллагааг дүгнэхэд нэг үзүүлэлт болгон оруулсан байна.			
4	15	Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29	16.4.. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн аймаг, нийслэл дэх дайчилж болох барилга байгууламжийн жагсаалтыг гаргаж Улсын онцгой комисст хүргүүлнэ.	Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 31 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангаж коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед тусгаарлан ажиллах зорилгоор Ховд их сургуулийн дотуур байр, Өргөө, Цамбагарав, Боорж, Минж, Роял, Велл зочид буудлуудыг тусгаарлан ажиллах байраар сонгон, хамтран ажиллах гэрээг байгуулж 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэл ойрын хавьтлын 1271 иргэнийг тусгаарлан, мэргэжлийн байгууллагууд хяналт тавин ажилласан байна. Тайлант онд коронавируст халдварын эрсдлийн үнэлгээгээр аймгийн хэмжээнд халдвар нь бага эрсдэлтэй байгаа тул эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны батлагдсан төсөвт хууль журмын дагуу зохицуулалт хийж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг байгууллагын саналыг үндэслэн зарцуулах эрхийг нээж халдварын үед байгууллагууд халдвараас сэргийлэх тасралтгүй үйл ажиллагааг хангах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.	100%	100%	

5	16	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ 2020-05-07 Дугаар 2020.07.01	15.2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, хотыг хөгжлүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг өмнөх баримт бичиг дуусгавар болохоос өмнө батална. /Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./	Ховд аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан хэлтэс, албан байгууллага, сумдаас саналыг тусган боловсруулж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг авч, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлснээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 2 дугаар хуралдааны 2/04 тоот тогтоолоор батлууллаа. Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл нь 8 бүлэг, 29 зорилт 164 арга хэмжээг хэрэгжүүлж, “Олон үндэстэн ястны эх хэл, түүх, зан заншил, соёл, өв уламжлал, эвсэг, хөдөлмөрч, бүтээлч чанарт суурилсан соён гэгээрүүлэх, хүний хөгжлийг дэмжсэн олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлнэ” гэсэн зорилгоо хангах юм.	100%	100%	
	17		17.4.. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг Засаг даргыг томилогдсоны дараах 45 хоногт багтаан батална.	Аймгийн “Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн төслийг боловруулахдаа Монгол улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал “Алсын хараа-2050” Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тургуурлан Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдуулан иргэд, төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, сумдын санал авах	100%	100%	

			хэлэлцүүлгүүдийг удаа дараа зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 1100 гаруй саналыг нэгтгэн боловрууллаа. Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 6 багц бодлогын асуудлын хүрээнд нийт 283 арга хэмжээг хэрэгжүүлж, “Иргэн төвтэй, байгальд ээлтэй хөгжлийн жил” болгон зарлаж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 5/02 тоот тогтоолоор батлуулж, үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөө, болон хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхойлон батлуулж, холбогдох байгууллага, сумдад хүргэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.			
18		18.6.. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор батална.	2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр хуралдсан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 5 дугаар хуралдааны 05 дугаар тогтоолоор 2021 оны хөгжлийн төлөвлөгөөг 89,9 хувьтай буюу “хангалттай” гэж үнэлээд 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэн баталсан бөгөөд 2023 оны төлөвлөгөөг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022-ны 10 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн 5 бүлэг, 19 зорилт, 151 арга хэмжээ бүхий бодлогын бичиг баримт батлуулсан байна.	100%	100%	
19		21.6.. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтуудын орон нутагт дахь хэрэгжилтийн явц, үр нөлөөний тайланг аймаг, нийслэлийн Засаг даргаас Засгийн газарт тогтоосон хугацаанд хүргүүлнэ.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн орон нутаг дахь хэрэгжилтийн явц болон үр нөлөөний тайланг тус хуулийн 21.4-т заасны дагуу Засгийн газраас шинэчлэн батлах журманд заасан хугацаанд Засгийн газарт хүргүүлсэн болно. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн тайланд арга хэмжээ болон зорилтын хүрээнд, мөн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн	100%	100%	

				биелэлт, үндсэн чиглэлийн биелэлт, үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тогтоосон хугацаанд нь ЗГХЭГ-т цаасаар хүргүүлсэн ба мөн new.unelgee.gov.mn сайтад шивж оруулан баталгаажууллаа. Баримт бичгийн төлөвлөлт, биелэлтэд чанарын үнэлгээ хийх, мөн хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, бодлогыг хэрэгжүүлснээр хүний хөгжил, нийгэм, байгаль орчин, эдийн засаг, засаглалын хүрээнд бий болох эерэг өөрчлөлт буюу үр нөлөөны тайланг гаргаж, зөвлөмж дүгнэлт өглөө. Хөгжлийн бодлогын дунд, богино хугацааны баримт бичгийн явцын тайланг тогтоосон хугацаанд Засгийн газарт журмын дагуу хүргүүлж хэвшсэн болно.			
6	20	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Төрийн байгууллагууд нь эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг өөрийн фэйж хуудас болон мэдээллийн самбарт байршуул, тухай бүр мэдээллийг шинэчлэн ажиллаж хэвшсэн байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын http://khovd.gov.mn/ цахим хуудас болон мэдээллийн самбарт байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт, тэргүүлэх чиглэл, 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг байршуулж, өөрчлөлт, шинэчлэлт, баяжуулалт хийх ажлыг тогтмол хийж ажиллалаа. Аймгийн Засаг даргын Тамгын газар орон нутгийн Ховд телевиз, newkhovd.mn сайт, khovdnews.mn сайтуудтай гэрээ байгуулан ажиллаж, энэ хугацаанд Тамгын газрын үйл ажиллагаатай холбогдолтой 400 гаруй мэдээ, мэдээлэл,	100%	100%	

			нэвтрүүлэг, видео шторк бэлтгэн http://khovd.gov.mn/, https://www.facebook.com/khovdnews.mn цахим хуудсанд нийтэллээ. 2022 онд аймгийн Засаг даргын Тамгын газрын алсын хараа, эрхэм зорилго, стратегийн зорилт болон байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан мэдээ, цаг үеийн ажлын мэдээ, мэдээлэл, аймгийн Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалыг тухай бүр нь цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан. Мөн Ховд аймгийн албан ёсны http://khovd.gov.mn/ цахим хуудасны хандалтыг нэмэгдүүлэх, цаг үеийн болон онцлох мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд цаг алдалгүй хүргэх зорилгоор Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар, Ховд аймгийн Засаг дарга Э.Болормаа пейж хуудаснууд ажиллуулж байна. Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар пэйж хуудас 22000 дагагчтай болж, пейж хуудас болон http://khovd.gov.mn/ цахим хуудсанд тус бүр 383 фото, 51 видео мэдээ бэлтгэн байршуулж, 140125 хүн хандан мэдээ, мэдээлэл авсан байна. “Ховд аймгийн Засаг дарга Энхбатын Болормаа” пэйж хуудас нь 11000 дагагчтай бөгөөд 65 фото мэдээ, 14 видео нийтлэн иргэд, олон нийтэд хүргэлээ.			
	21	8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Төрийн байгууллагууд болон аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтын хаяг байршил, харилцах утасны дугаар мэдээллийг иргэдэд ил тод байршуулан тухайн байгууллагын цахим хуудас болон http://khovd.gov.mn/?page_id=2301 цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан шинэчлэн ажиллаж байна	100%	100%	

	22	8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, бусад үйл ажиллагааны тайлан, хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгийн биелэлт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмжүүд мөн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжүүдийг аймгийн ЗДТГ-ын болон үнэлгээ хийсэн байгууллагын фэйж хуудас, гадна мэдээллийн самбар, аймгийн Төрийн аудитын болон Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны цахим сайтууд зэрэгт ил тод мэдээлж хэвшсэн болно.	100%	100%	
	23	8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Аймагт үйл ажиллагаа явуулдаг хууль, хяналтын байгууллагууд болон аймгийн Засаг даргын Тамгын газар нь хуулийн хэрэгжилтийн тайланг гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дагавар, үр нөлөөг тооцон ажиллаж байна. Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” батлах тухай 6 дугаар хавсралтын дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээг хийдэг. Тус аргачлалаар үнэлгээг хийх шалтгааныг тодорхойлохдоо 3.2.3 дахь заалтад “Захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл үүссэн бол” үр дагаврын үнэлгээ хийхээр заасан байдаг ба манай аймагт дээрх шаардлага гараагүй тул үнэлгээ хийгдээгүй байна.	Х.Б	Х.Б	
	24	8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Ховд аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн биелэлт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны	100%	100%	

				хөтөлбөр, үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн биелэлтийн тайлангийн дүн мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт мэдээлж хэвшсэн болно.			
	25		8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Төрийн байгууллагууд нь үйл ажиллагаандаа мөрдөж байгаа салбарын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад холбогдол бүхий эрх зүйн актуудын жагсаалтыг гаргаж мэдээллийн самбартаа байршуулах, байгууллагын цахим сайтын хууль, эрх зүйн булангаараа ил тод мэдээлж, иргэдэд хүргэж хэвшсэн болно.	100%	100%	
	26		8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Засгийн газрын 2021 оны аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай 377 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн “Зөвшөөрөл олгох тухай” 2022 оны 274 дүгээр тогтоолын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/71 дүгээр тушаалаар 17 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлаж тухайн албан хаагчдад танилцуулан мөрдөж ажиллаж байна. Түүнчлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заасан үүргийг гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа бүрэн тусгасан эсэхэд хяналт тавин ажиллалаа. Аймгийн Засаг даргын Тамгын газрын болон бусад төрийн байгууллагууд нь төрийн жинхэнэ албан хаагчдын хаяг, албан тушаалын нэр, зураг, өрөөний дугаар, утасны дугаар, мөн “таны хөтөч” булангаар албан хаагчдын өрөө, байршлыг зааж, байгууллагын мэдээллийн самбарт болон өөрийн цахим хуудас, khovd.gov.mn	100%	100%	

				иргэдэд ил тод нээлттэй байдлаар хэлтэс, албад, нэгж тус бүрээр байршуулсан болно.			
	27		8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, түүний Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч 25 агентлаг, 11 байгууллага, 17 сумын Засаг даргын Тамгын газар, 86 төсөвт байгууллага, 91 багт ирсэн санал хүсэлт, өргөдөл гомдлын мэдээг 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар нэгтгэн гаргахад нийт 15995 өргөдөл, гомдол хүлээн авч, 15039 өргөдлийг шийдвэрлэн хариу өгч, 647 өргөдлийг холбогдох байгууллага албан тушаалтанд уламжилж, 309 өргөдлийг шийдвэрлэх хугацаа болоогүй хүлээгдэж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 98.1 хувьтай байна. Мөн тайлант хугацаанд аймгийн Засаг дарга 550 иргэнийг биечлэн хүлээн авч уулзан асуудлыг шуурхай шийдвэрлэж, хариу өгч ажиллалаа. Эдгээрийг ирсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг төрлөөр нь ангилан авч үзвэл: Гэр хүссэн 30, мөнгөн тусламж, дэмжлэг хүссэн 28, төрийн дээд одон медалиар шагнуулахыг хүссэн 8, ажил хүссэн 26, газар хүссэн 27, санал 11, бусад асуудлаар 420 иргэний асуудлыг тус тус шийдвэрлэв. Түүнчлэн иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан аймгийн хэмжээнд буцалтгүй тусламж, санхүүгийн дэмжлэг хүссэн 444 өргөдөл ирүүлсний 147 нь шийдвэрлэж, 48,976,500 төгрөгийн санхүүгийн дэмжлэг, тусламж үзүүлсэн байна. Сумдын бичиг хэргийн эрхлэгч, хууль эрх зүйн ажилтнуудад нэгдсэн сургалтын үеэр "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэх" талаар 2 цагийн	100%	100%	

				сургалт хийж, үүрэг чиглэл өгч ажиллалаа. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл, тоо баримтыг ЗДТГ-ын мэдээллийн самбарт байршуулан, тухай бүр шинэчлэн ажиллаж байна.			
	28		8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Аймагт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагууд нь хуулиар хориглоогүй статистик мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт байршуулж, мөн аймгийн төв талбай дахь дэлгэцээр мэдээллээ хүргэн ажиллаж байна. Аймгийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүдийг статистикийн хэлтсээс сар, улирал бүрээр гаргаж, брошур болгон хэвлэдэг бөгөөд үндэсний статистикийн газрын цахим сайтад байршуулдаг байна. Ховд аймагт олборлох үйлдвэрлэл явуулж байгаа 3 аж ахуйн нэгж компани байгаа ба шилэн дансны нэгдсэн тайланд мэдээллийн талаар тоон үзүүлэлт, статистик тоо бүрэн гарсан бөгөөд мэдээллийг сар бүр хугацаанд нь оруулж хэвшсэн байна. Нийгмийн салбарын байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдал, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангахад мэдээллийг цахимжуулах зорилгоор эрүүл мэнд боловсролын салбарын тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгах, цуцлахыг e-mongolia сайтаар дамжуулан шийдвэрлэж, санхүү, хүний нөөц, худалдан авах үйл ажиллагааны мэдээллийг шилэн дансанд тогтмол байршуулж хэвшлээ. Мөн khovd.gov.mn цахим хуудсанд 560 захирамж, 40 тушаал байршуулан давхардсан тоогоор 86773 иргэнд мэдээлэл хүргэсэн байна.	100%	100%	
	29		8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	Сум байгууллагуудаас аймгийн 2022 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулах саналуудыг хүлээн авч аймгийн Иргэдийн	100%	100%	

			Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 173 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан, хяналт тавин ажиллаж байна. Нэгдсэн төлөвлөгөө нь Нийтээр тэмдэглэх баярын өдөр, Ойн арга хэмжээ, Нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, Тэмдэглэлт өдрүүд, Соёл урлаг, спортын арга хэмжээ, Сургалт, семинар, уулзалт, зөвлөгөөн, Бусад арга хэмжээ /судалгаа, аян, үзэсгэлэн/ гэсэн 7 бүлэгтэй бөгөөд 1 дүгээр бүлэг-9, 2 дугаар бүлэг-7, 3 дугаар бүлэг-14, 4 дүгээр бүлэг-3, 5 дугаар бүлэг-19, 6 дугаар бүлэг-13, 7 дугаар бүлэг-16, нийт 81 арга хэмжээг багтаасан бөгөөд тус нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн ЗДТГ-ын мэдээллийн самбар, фэйж хуудсуудаар иргэдэд хүргэсэн байна. Төрийн байгууллагуудаас зохион байгуулах олон нийтийг хамарсан арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг Ховд аймгийн албан ёсны цахим сайт, фэйж хуудас болон олон нийтийн телевиз, сонингуудаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэн танилцуулж хэвшсэн болно. Мөн аймгийн төв талбайд байрлах дэлгэцээр байнга мэдээлэл хийж хүргэдэг.			
	30	8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ” гэж зааснаар төрийн захиргааны албан тушаалын сул орон тооны мэдээлэл, сонгон шалгаруулалтын захиалгыг хуулийн хугацаанд нь ирүүлэх, хүлээн авч хуулийн хугацаанд нь Төрийн	100%	100%	

			албаны зөвлөлд хүргүүллээ.“Албан тушаалын сул орон тоог нөхөх зарим арга хэмжээний тухай” Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 411 дүгээр тогтоолын дагуу төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтыг халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулан сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу нээлттэй зарлаж, хууль болон тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлагын тусгай шаардлагыг хангасан төрийн албан хаагч, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй иргэн бүртгүүлэх, сонгон шалгаруулалтад тэгш оролцох, нээлттэй өрсөлдөх боломжийг бүрдүүлэх арга хэмжээг авч ажиллалаа. Аймгийн нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн төрийн захиргааны албан тушаалын сул орон тооны захиалгыг хүлээн авч нэгтгэн Төрийн албаны зөвлөлд тусгай шалгалтаар албан тушаалын сул орон тоог нөхөхөөр захиалгыг хүргүүлж, 2022 оны 02 дугаар сарын 14, 15, 21, 03 дугаар сарын 23, 24, 25, 06 дугаар сарын 16, 17, 8 дугаар сарын 23, 10 дугаар сарын 31, 11 дүгээр сарын 01 -ний өдрүүдэд тусгай шалгалтыг тус тус албан тушаалын ангилал тус бүрээр 23 удаа зохион байгууллаа.			
	31	8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Энэ онд 23 удаагийн тусгай шалгалтыг журамд заасны дагуу ил тод, нээлттэй зохион байгуулж, давхардсан тоогоор 250 албан тушаал зарлагдаж, төрийн захиргааны ахлах түшмэлийн удирдах албан тушаалд 5, төрийн захиргааны дэс түшмэлийн удирдах албан тушаалд 6, төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн албан тушаалд 6, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын дэс түшмэлийн албан тушаалд 46, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын	100%	100%	

			туслах түшмэлийн албан тушаалд 22 нийт 85 албан тушаалын сул орон тоог нөхөхөөр тус тусын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүллээ. Төрийн албаны тусгай шалгалтад төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын дэс түшмэлээс удирдах албан тушаалын ахлах түшмэлийн албан тушаалд төрийн жинхэнэ албан хаагч шатлан дэвшсэн 2, удирдах албан тушаалын дэс түшмэлийн албан тушаалд төрийн жинхэнэ албан хаагч шатлан дэвшсэн 4, дэс түшмэлээс дэс түшмэлийн ангилалд 4, туслах түшмэлээс дэс түшмэлийн албан тушаалд төрийн жинхэнэ албан хаагч шатлан дэвшсэн 6, туслах түшмэлээс туслах түшмэлийн албан тушаалд 1 төрийн жинхэнэ албан хаагч нэр дэвшсэн бол төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй 2019 оны 5, 2020 оны 8, 2021 онд 22, 2022 оны 22 иргэн, төрийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн нөөцөөс 2 иргэн тус тус нөөцийн бүртгэлээс төрийн жинхэнэ албан тушаалын тусгай шалгалтад оржээ.			
	32	8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга), төрийн албаны шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Ховд аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Чадварлаг, ёс зүй, хариуцлагатай төрийн алба”-тай болох зорилт тусган хэрэгжүүлж, үр дүнг ил тод тооцдог, хариуцлага, сахилгын механизмыг бүрдүүлэх, ёс зүйн өндөр шаардлагад нийцсэн төрийн албан хаагчдыг сурган хөгжүүлж, бүтээмж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг шинэ шатанд гаргахаар зорилт тавьж ажиллалаа. Аймгийн хэмжээнд 166 төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн судалгааг шинэчлэн гаргалаа. Аймгийн хэмжээнд нийт 114 ёс зүйн зөвлөлд 3 хүний бүрэлдхүүнтэй ёс зүйн зөвлөл 41, 5 хүний	100%	100%	

			бүрэлдхүүнтэй ёс зүйн зөвлөл 62, 6 хүний бүрэлдхүүнтэй ёс зүйн зөвлөл 1, 7 хүний бүрэлдхүүнтэй ёс зүйн зөвлөл 7, 9 хүний бүрэлдхүүнтэй ёс зүйн зөвлөл 3 тус тус ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг сум, байгууллага бүр цахим хуудсаар болон төрийн албан хаагч, иргэдэд ил тод харагдахуйц газар байрлуулан ажиллаж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны зөвлөлийн аймаг дахь салбар зөвлөлөөс “Шинэ сэргэлтийн бодлого, төрийн бүтээмжийн сэргэлт, стандарттай төрийн үйлчилгээ” сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтын төгсгөлд Төрийн албаны зөвлөлийн аймаг дахь салбар зөвлөлийн дарга Д.Энхболд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга нар болон сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нартай "Ёс зүйн дүрэм"-ийг сахих хариуцлагын гэрээ байгууллаа.			
	33	8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	Төрийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлэн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр бодлогын зөвлөгөө, дэмжлэгээр хангах, нутгийн захиргааны хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тэдгээрийг сургах, давтан сургах, төрийн албанд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, түүнд судалгаа шинжилгээ хийх, хууль тогтоомжийн биелэлтийг тооцон дүгнэж байна. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг https://khovd.gov.mn/ цахим хуудсанд байршуулж, тухай бүр нь шинэчлэн ажиллаж байна. Ховд	100%	100%	

			аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба” гэсэн бүлэг заалт оруулан батлуллаа. Үүнд: “Хариуцлагатай тунгалаг төр” хөтөлбөрийг үргэлжлүүлэхийн зэрэгцээ “Стандарттай Ховд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудад төрийн үйлчилгээний үндэсний стандарт нэвтрүүлж, төрийн үйлчилгээг соёлтой хүртээмжтэй шуурхай, хүнд сурталгүй хүргэх, Төрийн албан хаагчдын сургалтын болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж, мэдлэг чадвар, хандлагыг эрс шинэчлэх, Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах, Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтыг хууль журмын хүрээнд ил тод нээлттэй зохион байгуулж, гагцхүү чадахуйн зарчмын хүрээнд томилгоо хийнэ гэж тусгасан байна.			
	34	8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар аймгийн Засаг даргын Тамгын газрын https://khovd.gov.mn/ цахим хуудсанд ойлгомжтой байдлаар байршуулан баяжилтыг тухай бүр нь хийж, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбогдолтой мэдээ, мэдээллийг http://khovd.gov.mn/ цахим хуудсанд байршуулан иргэд, олон нийтэд мэдээлж, мэдээллийг тогтмол шинэчлэн, баяжуулалт хийж ажиллав. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар	100%	100%	

			тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичиг болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2-д заасны дагуу үйл ажиллагааны болон хүний нөөцийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд үнэлгээ өгөхөд 2021 оны байдлаар 97.8 хувьтай үнэлэгдсэн байна..			
	35	8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 4.1 дэх заалтын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, 2022 оны 12 сарын 15-ны А/116 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг үнэллээ. 2022 онд аймгийн Засаг даргын Тамгын газар нь ХШҮМЦС https://khovd.igovernment.mn/law/ болон гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим сан http://plan.igovernment.mn –г нэвтрүүлсэнтэй холбоотой байгууллага, нэгж болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн тайланг тус цахим сангаар тайлагнасан болно.	100%	100%	
	36	8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	Монгол улсын Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг цаг тухай бүр байршуулж байна. Өмнөх оны буюу 2020 оны Ховд аймгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийг 2021 оны 4 дүгээр сарын 25-ны дотор, 2021 оны Ховд аймгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийг 2022 оны 4 дүгээр сарын 25-ны дотор тус тус байршуулсан бөгөөд өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсвийн жилийн төсөв, дараа оны төсвийн төслийг жилд нэг удаа	100%	100%	

			тайлагнадаг ба тогтоосон хугацаанд тайлагнаж, мэдээлсэн байна.			
37		8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг жилд нэг удаа тайлагнахаас хугацаанд нь тайлагнаж, нийтэд мэдээлсэн болно.	100%	100%	
38		8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлангаар зөрчилгүй санал дүгнэлт авч, дүгнэлтийг цахим хуудас болон ил тод байдлын самбараар тайлагнасан болно.	100%	100%	
39		8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	Аймгийн Иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн 2022 оны 06 дугаар сарын 10-ны 7/04, 12 дугаар сарын 01-ний 10/08 дугаар тогтоолоор улсын тэмдэгтийн хураамж, зам ашигласны төлбөр хураамжийг шинэчлэн тогтоох тухай тогтоолыг тус тус батлуулж, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн баталгаажуулж 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдүүлэхээр сум байгууллага, цахим сайт, шилэн дансанд оруулан мэдээллээ. Хавсралт : 2 файл	100%	100%	
40		8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	Төсвийн хэмнэлт, хэтрэлт түүний шалтгаан тайлбарыг улирал бүрийн дараа сарын 8-ны дотор байршуулж, тайлагнасан болно.	100%	100%	
41		8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	5,0-20,0 хүртэлх сая төгрөгийн үнийн дүнтэй шууд худалдан авалт хийхдээ, аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн мэдээллийн сангаас байгууллага, аж ахуйн нэгжээ сонгож, ажлын даалгавар, саналаа хүргүүлэн, нийлүүлэгч байгууллагаа сонгон шалгаруулж байна. Үр дүнг байгууллагын мэдээллийн самбар болон фэйж хуудсаар	70%	70%	

				мэдээлж, аймгийн ХААА-нд хүргүүлэн ажилладаг. Шилэн дансны мэдээлэлд 5 сая төгрөгнөөс дээш дүнтэй хөрөнгө оруулалтын зарлагын гүйлгээг сар бүр оруулан ажиллаж хэвшсэн болно.			
	42		8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	Цалингийн зардлаас бусад таван сая түүнээс дээш төгрөгийн үнийн дүнтэй Засаг дарга, Орон нутгийн хөгжлийн сан, Орон нутгийн хөрөнгө оруулалт, Улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтын гүйлгээг сар бүрийн 8-ны дотор шивж нийтэд мэдээлж хэвшсэн болно.	100%	100%	
	43		8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	Ховд аймгийн хэмжээнд тайлант хугацаанд бонд, зээл, өрийн бичиг, баталгаа түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ зэрэг үйл ажиллагаа хийгдээгүй бөгөөд тайланг хугацаанд нь тайлагнасан болно.	100%	100%	
	44		8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар шилэн дансны сайтад орон нутгийн нийт 17 сум, 89 байгууллагын 15954 мэдээллийг байршуулахаас 15631 мэдээллийг байршуулсан байна. Нийт байршуулсан 15631 мэдээллийн 14100 мэдээллийг хуулийн хугацаанд, 1531 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна. Үүнээс Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны мэдээлэл 97.1 хувьтай, төсвийн байгууллагуудын мэдээлэл 98.3 хувь, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын мэдээлэл 96.3 хувийн дундаж үзүүлэлттэй байна. Аймгийн орон нутгийн байгууллагуудын нийт дундаж үзүүлэлт 98.0 хувьтай мэдээлсэн байна.	100%	100%	

45	8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;	Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, тендерийн урилга, тендерийн үнэлгээг цахим хуудсанд 1 – 3 хоногт байршуулдаг ба үнэлгээний хорооны дүгнэлт гарсан өдөрт нь цахим системд үр дүнг нийтлэн, тендерт оролцогчдод материалыг хуулийн хүрээнд ил тод болгож, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэл зэргийг цаг тухайд нь ил тод мэдээлж ажилласан болно.	100%	100%	
46	8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;	2021 оны улсын болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ажилд төрийн аудитын газраас аудит хийж, аудитын тайланг шилэн дансанд байршуулж, ажлаа дутуу хийсэн 27 компанид 7 дугаар сарын 20 -ны дотор дутуу ажлаа хийж дуусгах талаар аймгийн Засаг даргын орлогч Т.Дэлгэрсайхан албан бичиг хүргүүлэн үүрэг даалгавар өгч гүйцэтгүүлсэн ба энэ талаарх тайлан мэдээллийг аймгийн төрийн аудитын цахим сайтад байршуулан ажиллаж байна.	100%	100%	
47	8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	Зэвсэгт хүчний 123 дугаар анги, Нисэх буудал, Политехник коллеж, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Татварын хэлтэс зэрэг байгууллагууд болон 17 сумын Засаг даргын орлогч нарт болон бусад мэдээлэл хүссэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, зааварчилгаагаар хангаж, мэдээ, мэдээлэл хүргэж ажилласан болно	100%	100%	

	48		8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	Энэ жил улсын төсвийн хөрөнгөөр 38 төсөл арга хэмжээ, сайдын багцын 3 төсөл арга хэмжээ нийт 41 төсөл арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөснөөс орон нутагт 25 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжин ирж, худалдан авах ажиллагааг зарлан ажлаа гүйцэтгэж байна. Мэргэжил арга зүйн зөвлөгөө шаардлагатай төсөл арга хэмжээнүүдэд тус салбарын мэргэжлийн байгууллагуудтай захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Үйлдвэрлэгч Ховд хөтөлбөрийн хүрээнд жижиг дунд үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд Progress төслөөс 300 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. Хашаандаа сайхан амьдарья төслийн хүрээнд 116 айл өрхийг төвлөрсөн шугам сүлжээнд холбож цэвэр усны тоолуур суурилуулсан байна. Төсөл арга хэмжээний явцын мэдээллийг тухай бүрт нь Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын цахим хуудас, худалдан авах ажиллагааны цахим хуудас, мөн өдөр тутмын сонингоор дамжуулан иргэд олон нийтэд мэдээлэн ажиллаж байна.	100%	100%	
	49		8.4.27. мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	Ховд их сургууль 2021-2022 оны хичээлийн жилд олон улсын хамтарсан 5, ШУТИС-ийн суурь судалгааны 6, Азийн хөгжлийн банк, Жендерийн үндэсний хороо хамтарсан 2, аймаг орон нутгийн захиалгат гэрээт төсөл 11, Ховд их сургуулийн дотоод 7 төсөл нийт 31 төсөл хэрэгжүүлж, судалгаа, шинжилгээний ажил хийж гүйцэтгэсэн бөгөөд, эрдэмтэн багш нараас хийж буй судалгаа, шинжилгээний ажлуудыг сургуулийн веб сайтад мэдээлж байна. Мөн орон нутгийн төсвийн 2022 оны 1-4 дүгээр улирлын гүйцэтгэлд судалгаа, шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлын	70%	70%	

				чиглэлийг гарган танилцуулга бэлтгэн боршур болгож аймгийн удирдлагууд, сонирхсон иргэдэд хүргүүлж, байгууллагын дотоод сүлжээгээр нийтэд ил тод мэдээлэв.			
	50		8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:)	2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А_х0000_3 дугаар тушаалаар “Үнэлгээний хорооны үйл ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулах журам”-ыг баталсан бөгөөд, тендерииг нээсний дараа 1–3 өдөрт багтаан үнэлэх, үнэлгээний хорооны хурлыг нээлттэй, ил тод байдлаар лайваар шууд иргэдэд хүргэх гэх мэт өөрчлөлтийг оруулж, дээрх шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2022 онд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд амжилттай зохион байгуулсан ба төлөвлөгөөний биелэлт 2022 оны жилийн эцсийн байдлаар 100,0 хувь цахим системд бүрэн зарлагдсан биелэлттэй байна	100%	100%	
	51		8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	Аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бүх байгууллагууд үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл болон бусад мэдээллүүдийг өөрийн байгууллагын цахим сайт, байгууллагын мэдээллийн самбар зэрэгт загвар байдлаар гарган сурталчилж, иргэдийг хүндрэлгүй үйлчлүүлэхэд дөхөм үзүүлэн ажиллаж байна. Жаргалант суманд болон бусад сумдын ЗДТГ-т байрлах нэг цонхны үйлчилгээний төв нь иргэдэд төрийн үйлчилгээг нэг дороос хүндрэл чирэгдэлгүй үйлчлэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд тухайн үйлчилгээтэй холбоотой бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг мэдээллийн самбараар хүргэн ажиллаж байна. 2023 оноос эхэлх аж ахуйн нэгж,	100%	100%	

				байгууллагуудад үйлчилгээ үзүүлэх нэг цонхны үйлчилгээний газрыг нээхээр төлөвлөн ажиллаж байна.			
	52		8.5.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журмыг khovd.khural.mn, khovd.khural.mn, khovd.gov.mn болон Ховд аймгийн Засаг даргын тамгын газар, Хууль, эрх зүйн мэдээлэл, сурталчилгааг фэйсбүүк хуудсуудад байршуулж иргэдэд мэдээлэл хүргэж байна. Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлд зааснаар аймаг орон нутагт Байгаль орчны чиглэлээр 9 тусгай зөвшөөрөл, 8 энгийн зөвшөөрөл, Барилга хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр 14 тусгай зөвшөөрөл, 1 энгийн зөвшөөрөл, Соёл, боловсролын чиглэлээр 3 тусгай зөвшөөрөл, Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр 3 тусгай зөвшөөрөл, Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар 1 тусгай зөвшөөрөл, 1 энгийн зөвшөөрөл, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр 2 тусгай зөвшөөрөл, 1 энгийн зөвшөөрөл, Эрүүл мэндийн чиглэлээр 10 тусгай зөвшөөрөл, Эрчим хүчний чиглэлээр 11 тусгай зөвшөөрөл, Зам тээврийн хөгжлийн чиглэлээр 2 энгийн зөвшөөрөл буюу нийт 53 тусгай зөвшөөрөл, 13 энгийн зөвшөөрлийг тус тус олгохоор заасан байна. Аймгийн хэмжээнд зөвшөөрөл олгож буй үйл ажиллагаанд аливаа зөрчил, дутагдал илрээгүй бөгөөд хууль, журмын дагуу зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулж байгаа болно. Зөвшөөрлийн тухай хуулиар олгогдох тусгай болон энгийн зөвшөөрлийг нэгтгэсэн, хассан, шилжүүлсэн, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн харъяалал өөрчлөгдсөнтэй холбогдуулан зөвшөөрлийн харилцааг зохицуулж	70%	70%	

			байгаа нутгийн захиргаанаас гаргасан шийдвэрийг энэ хуульд нийцүүлэхээр холбогдох арга хэмжээг авч шийдвэрлэхээр санал боловсруулан ажиллаж байгаа болно.			
53		8.6.1. олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;	2022 онд олон нийтээр дагаж мөрдөхөөр 12 хэм хэмжээний акт гаргаж аймгийн ИТХ-аар батлуулан журмын дагуу бүртгүүлж legalinfo.mn сайтад тавигдсан бөгөөд сумд мөрдөж эхлээд байна. Захиргааны хэм хэмжээний актын төслүүдэд хуульд заасан дүрэм журмын дагуу нөлөөлийн шинжилгээ хийдэг. Тус актуудын төслийг урьдчилан гаргаж сум, байгууллагууд, төрийн бус байгууллага, иргэд олон нийтээс санал авч тусгасан байна. Мөн актуудад санал авах тухай мэдээллийг аймгийн сайт khovd.gov.mn болон аймгийн Засаг даргын Тамгын газрын пэйж хуудсанд байрлуулан тус хуулийн хэрэгжилт, ил тод байдлыг ханган ажиллав.	100%	100%	
54		8.6.2. эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	2020 онд батлагдсан “Оюуны өмчийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтад “Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид "оюуны өмчийн байгууллага" гэх/ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд орон нутагт хэлтэс, тасаг байгуулж, эсхүл оюуны өмчийн улсын байцаагч ажиллуулж болно” гэж заасан бөгөөд манай аймагт одоогоор оюуны өмчийн байгууллага болон байцаагч ажилладаггүй тул эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт нь "Оюуны өмчийн мэдээллийн нэгдсэн сан"-д бүртгэлтэй байгаа болно.	Х.Б	Х.Б	
55		8.6.3. хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд	Аймгийн ерөнхий төлөвлөгөөг хийлгүүлэхэд шаардлагатай төсөв, ажлын даалгаврын төслийг	100%	100%	

		нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	боловсруулан аймгийн ИТХ-д хүргүүлж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10 дугаар хуралдаанаар орон нутгийн 2023 оны төсөвт 153,9 сая төгрөг, Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох төслөөс 70 хувь буюу 359,1 сая төгрөгийг төсөвт суулгасан бөгөөд тухайн шийдвэрийг аймгийн ИТХ болон аймгийн ЗДТГ-ын албан ёсны сайт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллээ.			
	56	8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Төрийн байгууллагын болон хуулийн этгээдийн эзэмшил газрын мэдээллийг egaazar.gov.mn цахим сайтаас нээлттэй харах боломжийг бүрдүүлсэн бөгөөд эзэмшил газрын мэдээллийг авах бүрэн боломжтой. Аймгийн газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөний дагуу 1966 нэгж талбарыг газрын нэгдмэл сангийн ангилалаар нь оруулснаас 1170 нэгж талбар буюу өвөлжөө хаваржааны доорх 211 нэгж талбарын 48,1 га, гэр орон сууц, хашааны 182 иргэний 82,5 га газарт, төмс хүнсний ногоо, усалгаатай болон усалгаагүй тариалан, жимс жимсгэнэ, үр тарианы ердийн хадлан, мод үржүүлгийн зориулалттай 246 нэгж талбарын 3107,7 га газарт, төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд 30 нэгж талбарын 22 га газарт, бусад арга хэмжээний хэрэгцээнд 373 нэгж талбарын 154,5 га газрыг кадастрын зургаар баталгаажуулж, газрын мэдээллийн цахим системд орууллаа. Цахим системийг байгууллагын цахим хуудас, фэйсбүүк хуудсаар дамжуулан сурталчилсан бөгөөд орон нутгийн телевиз, сайтуудад нөхөн бүрдүүлэлт, газрын дуудлага худалдаа, газар зүйн нэрийн зөвлөл, 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний талаар ярилцлага, мэдээлэл өгөв. Цахим систем ашиглах, зөвлөх	100%	100%	

				үйлчилгээ үзүүлэх, цахим хэрэглээнд нэвтрэх боломжгүй иргэдэд цахим шилжилтийг хүргэх зорилгоор “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д 2 мэргэжилтнийг ажиллуулж үйлчилгээ үзүүлж байна. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд өөртөө үйлчлэх буланг байгуулж, киоск машинаар үйлчилгээ авч байна.			
	57		8.6.5. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;	Манай аймагт төрийн өмчит 2, орон нутгийн өмчийн оролцоотой 168 байгууллага, ОНӨААТҮГ 5, тусгай сан 60 нийт 233 байгууллага, үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн санхүүгийн тайланг шилэн дансанд хуулийн хугацаанд нь ил тод мэдээлж байна. Ховд аймагт үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын нэр болон ашиг, алдагдлын үзүүлэлт Төрийн өмчит үйлдвэрийн газруудын ашиг алдагдал 2021 оны жилийн эцсээр доорхи үзүүлэлттэй гарсан. /сая төгрөгөөр/ байна. Үүнд: Дөргөн УЦС ХХК-1135.5 алдагдалтай, Цахилгаан түгээх сүлжээ ХХК 178.4 ашигтай, Ховд АЗЗА ХК 5.3 ашигтай, Ховд Дулааны станц 162.8 төгрөгийн ашигтай ажиллажээ. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын ашиг алдагдлын хэмжээ /сая төгрөгөөр/ Шим ус 248,9 ашигтай, Мянган угалзат -192,6 алдагдалтай, Ховд суварга -40,1 алдагдалтай, Тээлийн илч 0, ашигтай, Мянгад шим ус -1, алдагдалтай, Минжит булган хот тохижилт -4,4 алдагдалтай, Алтай шим ус -3,1 алдагдалтай, Үенч мөнх ундрага баялаг 0,0, Зэрэг шим ус -3,0 алдагдалтай, Шинэ Ховд ББХК 3,5 ашигтай, Шинэ Ховд Жаргалант ТҮК -69,4 алдагдалтай, Хар Ус ОНӨААТҮГ 0,0, Мянган	100%	100%	

				Сутайн Буян 3,6 сая төгрөгийн ашигтай тус тус ажилласан байна.			
	58		8.6.6. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;	Шилэн дансны тухай хуулийн дагуу цахим хуудсанд төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд хуулийн хугацаанд тайлан мэдээгээ гаргаж, нийтэд ил тод мэдээлж байна. Аймгий орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх Нийтийн аж ахуйн үйлчилгээний Шим- ус ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөл, Ховд суврага ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөл, Мянган угалзат суврага ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 14 дүгээр тогтоолоор, 2021 оны 02 дугаар сарын 05-ны 11 тогтоолоор "Шинэ Ховд Баруун бүсийн хөгжлийн корпораци "ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөл, Шинэ-Ховд-Жаргалант тохилжилт үйлчилгээний компани ОНӨААТҮГ--ын ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнийг баталж, http://khovd.khural.mn/t/ цахим хуудас болон мэдээллийн самбарт ил тод байрлуулан ажиллаж байна.	70%	70%	
	59		8.6.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;	Аймагт үйл ажиллагаа эрхэлж байгаа орон нутгийн өмчит 5 хуулийн этгээдийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах тухай шийдвэрийг аймгийн ИТХ-аас тогтоол гарган шийдвэрлэж байгаа бөгөөд, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх тайлан мэдээ	70%	70%	

				бүрэн эцэслэж гараагүй ба дээрх шийдвэрийг аймгийн ИТХ-ын цахим сайтад оруулж, иргэд, олон нийтэд ил тод мэдээлж байгаа болно.			
	60		8.6.10. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;	"МоЭнКо" ХХК-ийн уурхайн нөлөөллийн бүсэд Дарви сумын 77 айл өрхөд нийт 260.0 сая төгрөгийн нөхөн олговор олгохоор тусгагдсан ба Эрдэнэбүрэнгийн УЦС-н нөлөөллийн бүсийн айл өрхүүдэд нөхөн олговор олгохоор Засгийн газраас баталсан байна. "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих" төслийн хэрэгжилтийн явц, үүсээд байгаа нөхцөл байдлын улмаас нөлөөлөлд өртөж байгаа айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, соёлын биет болон биет бус өвийг авран хамгаалах ажилд иргэд, иргэний нийгмийн болон төрийн захиргааны байгууллагуудын уялдаа холбоог хангаж, төслийн ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахын тулд орон нутгийн зүгээс шаардлагатай мэдээ, мэдээлэл, айл өрхүүдийн судалгааг гарган эхний улиралд багтаан төсөл хэрэгжүүлэх байгууллагад албан бичгээр хүргүүлсэн болно. Энэ талаарх мэдээллийг аймгийн цахим хуудас болон фэйсбүүк, фэйж хуудсуудаар иргэд олон нийтэд хүргэж, төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр Засгийн газраас гарсан тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор эерэг байдлаар хандахыг уриалж байна	100%	100%	
	61		8.6.11. барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар орон сууцны 14 барилга хүлээж авав. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дөргөн сумын төвд нийт 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 ортой эмнэлэг ашиглалтад орсон бөгөөд дүгнэлтийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын цахим хуудсаар дамжуулан	100%	100%	

			иргэд олон нийтэд мэдээлэл хүргэн ажиллаж байна.			
62		8.6.13. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;	Ховд аймагт одоогийн байдлаар бүртгэгдсэн гэрээ 22 байгаа бөгөөд Дарви сумын нутагт үйл ажиллагаа “МоЭнКо” ХХК-ийн Хөшөөтийн нүүрсний уурхайг ашиглах төслийн гэрээг аймгийн Засаг даргатай байгуулсан ба хамтран ажиллах энэхүү гэрээг нэг талаас Ховд аймаг, түүнийг төлөөлж тус аймгийн Засаг дарга Б.Дүгэржав, нөгөө талаас МоЭнКо ХХК, түүнийг төлөөлж Дэд захирал Ж.Оюунчимэг нар 2021 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр байгуулсныг 2022 онд шинэчилсэн ба Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран ажиллах гэрээг Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга, www.iltodgereee.mn сайтад байршуулан ажиллаж байна. Мөн аймгийн ЗДТГ-ын khovd.gov.mn цахим сайтад ил тод байршуулан мэдээлж байна.	100%	100%	
63		8.6.20. нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	Аймгийн хэмжээнд төрийн өмчит болон хувийн хэвшлийн барилга байгууламжууд, инженерийн шугам сүлжээ, тохижилт, зам тээврийн URBAN.GOV.MN мэдээллийн санд оруулах 4 эрхтэйгээр аймгийн хэмжээний мэдээллийн сан үүсгэх ажил хийгдэж байна. Мөн худалдан авах үйл ажиллагаа, Захирамж, Тушаал, тусгай зөвшөөрлүүдийн мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй байршуулж байна. Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо, мэдээллийн урсгалыг сайжруулах, хариуцлага, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор аймгийн 17 сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем” нэвтрүүлж, https://operator.e-	100%	100%	

			mongolia.mn/auth/login системээр дамжуулан 66 төрлийн үйлчилгээгээр 6000 лавлагаа, тодорхойлолт гаргаж, иргэдийг олон төрлийн үйлчилгээг нэг дороос авах боломжоор хангалаа. “Цахим Ховд” аймгийн дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, цахим үйлчилгээний нэгдсэн портал www.egr.e-mongolia.mn системд 17 сум болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 25 агентлаг, төсөвт байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд болох 78 байгууллага холбогдож, албан хэрэг хөтлөлтийг цахимаар шийдвэрлэж байна. Дээрх цахим сайтууд болон нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй төрийн үйлчилгээ авч болох цахим сайтуудыг хэрэглэх, мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдлийг хэрхэн ашиглах талаар иргэдэд зөвлөмж хүргэн ажиллаж байна.			
64	8.6.21. мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс аймгийн Засаг даргын нэрэмжит “Чадварлаг мэргэжилтэн-Шинэ Ховдын ирээдүй” тэтгэлэг олгох журмыг байгууллагын болон орон нутгийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэд олон нийтэд суртчилан, журмын болзол хангасан Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2, Шинжлэх Ухаан Технологийн Их сургуулийн 1, Ховд Их Сургуулийн 6, мэргэжил дээшлүүлэх институтэд Резидент 1, нийт 10 оюутан, суралцагчид 12.0 сая төгрөгийн дэмжлэг, элсэлтийн ерөнхий шалгалтад амжилттай оролцож 800 оноо авсан 5 сурагч, 750 дээш оноо авсан 18 сурагч нийт 23 сурагчийг 11,2 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан бөгөөд дээрх мэдээллийг аймгийн цахим хуудас, бусад мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн болно. Орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг төрийн байгууллагуудаас өөрийн	100%	100%		

				зардлаар суралцуулж буй тохиолдол гараагүй болно.			
	65		8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:)	Албан бичгийн эргэлтийг цахимжуулах, төрийн үйлчилгээний шуурхай, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зорилгоор төрийн болон нутгийн захиргааны 108 байгууллагад Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын www.erp.e-mongolia.mn нэгдсэн платформыг нэвтрүүлэхээр төлөвлөн судалгаа гарган нэгтгэж, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлээ. Мөн http://khovd.gov.mn/ https://www.facebook.com/khovdnews.mn цахим хуудсаар дамжуулан сурталчилж, олон нийтэд хүргэн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Төрийн байгууллагууд нь дээрхээс гадна байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээллийг өөрийн цахим хуудас, фэйсбүүк, фэйж хуудсуудаар болон орон нутгийн телевиз, сонингуудаар дамжуулан иргэдэд сурталчлан, мэдээлэл хүргэн ажиллаж байна. Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгаж байгаа болно..	70%	70%	
7	66	Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2021-12-24 Дугаар 2021-12-24	11.3. Улсын Их Хурлаас энэ хуулийн 11.2-т заасны дагуу Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд Улсын Их Хуралд ирүүлэх ба түүнд Тамгын газар дүн шинжилгээ хийж, танилцуулгыг холбогдох Байнгын хороодод хүргүүлнэ. (11.2.Улсын Их Хурал	Улсын Их Хурлаас энэ хуулийн 11.2-т заасны дагуу манай аймагтай холбогдолтой хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг шийдвэрлүүлэхээр тогтоол гаргаж ирүүлээгүй болно.	100%	100%	

			шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана.)				
8	67	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2022-07-05 Дугаар 2023.01.01	15.7. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, эрүүл мэнд, соёл, спортын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон дотуур байрны байршил, аймаг, нийслэлийн саналыг харгалзан хүнс, эрүүл мэнд болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тогтооно.	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн аймгийн Засаг даргын орлогч холбогдох дүрэм журмын дагуу олгодог бөгөөд, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ хууль мөрдөгдөж эхэлсэн, мөн Мэргэжлийн хяналтын газар татагдан буугдсантай холбоотойгоор согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий комиссыг шинэчлэн баталж, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл авсан 520 аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих аттетасчлалын шалгалтыг 2023 оны 02 дугаар сарын 1-ний өдрөөс 03 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгууллахаар төлөвлөн ажиллаж байна.	70%	70%	
	68		23.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх	Шинэчлэн батлагдсан хууль хэрэгжиж эхэлсэнтэй уялдан "Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2.1, 16.2.2 дахь заалтуудыг үндэслэн согтууруулах ундаа худалдах,	70%	70%	

			тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтооно.	түүгээр үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж байгууллагуудын цагийн хязгаарыг тогтоох захирамжийн төслийг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна.			
УИХ-ын тогтоол							
9	69	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2017-06-09 Дугаар 2017 №46	1.10.. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнийг хөгжүүлэх төвүүдийг аймаг, дүүрэгт байгуулах;	Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийг Азийн хөгжлийн банкны хөнгөлөлтэй зээлийн 5.1 тэрбум төгрөгийн дэмжлэгээр барьж барилгын ажлын гүйцэтгэл 95 хувийн гүйцэтгэлтэй байна.	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх
10	70	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2021-07-07 Дугаар 2021 №67	1.1.ж/. цар тахлын үед хүүхэд, зорилтот бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах, хүүхэд хамгааллын байцаагчийн тоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын асуудалд нэн шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг ямар ч нөхцөлд хасахгүйгээр, цогц	2022 онд аймгийн орон нутгийн төсвөөс халдвараас сэргийлэх, тусламж үйлчилгээний нөөц бүрдүүлэхэд 300.0 сая төгрөгийг төсөвлөсөн бөгөөд Коронавируст халдварын эрсдлийн үнэлгээгээр аймгийн хэмжээнд халдварын бага эрсдэлтэй үнэлэгдсэн тул байгууллагуудын 2022 оны батлагдсан төсөвт хууль журмын дагуу зохицуулалт хийж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг байгууллагын саналыг үндэслэн зарцуулах эрхийг нээж өгснөөр халдвараас сэргийлэх тасралтгүй үйл ажиллагааг хангах нөхцлийг бүрдүүллээ. 2021 оноос эхлэн Ховд аймгийн Цагдаагийн газарт 1, Булган суман дах Сум дундын Цагдаагийн хэлтэст 1 нийт 2 хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн томилогдон ажиллаж байна.	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх

			байдлаар төсөвлөх, шаардлагатай тохиолдолд төсвийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:)				
УИХ-ын байнгын хорооны тогтоол							
11	71	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ	2.1/. Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах;	Хүн амын дунд тохиолдох бэлгийн замын дамжих халдварын тархалтыг бууруулах, таслан зогсоох чиглэлээр аймгийн 2021-2025 оны хөгжлийн төлөвлөгөөний 2.2.2-т, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2-д Халдварт өвчний тандалт сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлж, бэлгийн замаар дамжих халдвар, сүрьеэ өвчний тархалтыг хязгаарлах, 2.1.1-д “Эрүүл иргэн” аймгийн дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж, иргэдийг жил бүр халдварт өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулан өвчлөл, нас баралтыг бууруулах асуудлуудыг жил бүрийн төлөвлөлтөндөө тусган ажиллаж байна. Тус онд давхардсан тоогоор шинээр хяналтанд орсон жирэмсэн 6419 эмэгтэйчүүдэд БЗДХ-ын илрүүлэх шинжилгээг хийж 21 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 18 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Мөн сонгосон сумд болох Мөнххайрхан, Мөст, Манхан Мянгад, Цэцэг сум, Хөшөөтийн уурхайн Алтайн зам компанийн 593 ажилчдыг ХДХВДОХ, тэмбүү, сүрьеэ илрүүлэх үзлэгт хамруулж, БЗДХ-ын	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх

				11 тохиолдлыг илрүүлэн бүртгэж хяналтандаа авч эмчилгээнд хамруулжээ. Мөн амбулаториор 2838 хүнд үйлчилж ХДХВ илрүүлэх шинжилгээг хийж 1 тохиолдлыг илрүүлэн хяналтанд авч, хавьтлын 138 иргэнд шинжилгээ бүгд сөрөг гарсан байна.			
	72		2.2/. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих.	Хүн амын дунд нийтлэг, урьдчилан сэргийлж, эрт үед нь илрүүлж, эмчлэх боломжтой халдварт бус өвчин зонхилж, аймгийн хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаанд зүрх судасны тогтолцооны өвчин, хавдар, гадны шалтгаант гэмтэл, хордлоготой холбоотой эмгэгүүд зонхилж, хүн амын нас баралтын 77.0 хувийг эзэлж байна. Дээрх халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлж, эрүүл амьдрах нөхцлийг дэмжихэд чиглэсэн “Эрүүл иргэн”, “Эх хүүхдийн ээлтэй тусламж үйлчилгээ”, “Чадварлаг эмч мэргэжилтэн”, “Эрүүл эр хүн” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, үйл ажиллагааны зардалд 170.0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн хөгжлийн сангаас үзүүлж эрчүүдэд зонхилон тохиолдох өвчин эмгэгийн оношилж эмчлэх "Андрологийн кабинет" байгуулах, сувилагч, дунд мэргэжилтнийг орон нутагт ажлын байран дээр нь чадавхижуулах "Сувилахуйн төв" байгуулсны зэрэгцээ хүн амын тусламж үйлчилгээний эрүүл аюулгүй байдлыг хангах, ая тухтай орчин нөхцөлд үйлчилгээ үзүүлэх зорилгоор Мөст, Дарви сум, Баатархайрхан өрхийн эмнэлэг, Эрүүл мэндийн газрын барилгыг засварлаж, сумын эмнэлгүүдийг амьсгалын замын эмгэгийг эмчлэх хүчилтөрөгчийн эмчилгээний тоног төхөөрөмж, компьютер нийлүүлэх зэрэг арга хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангаас нийтдээ 1368.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүллээ	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх

12	73	Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ	1.6/. Улсын хэмжээнд сум бүрийг “Ахмадын өргөө”-тэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх, ажиллаж буй ахмадын урамшууллыг тухайн орон нутгийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх;	Аймгийн хэмжээнд 14 суманд ахмадын өргөө байгуулан, урсгал зардал, тоног төхөөрөмжийг сум орон нутгийн төсвөөс шийдвэрлэж үйл ажиллагаагаа зохион байгуулж байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 69 дүгээр тогтоолоор “Ахмадаа ачилъя” дэд хөтөлбөрийг батлуулж 3 зорилтын хүрээнд 18 арга хэмжээ төлөвлөснөөс 15 арга хэмжээ хэрэгжиж 72,2 хувийн хэрэгжилтэй байна. Орон нутгийн ахмадын амралт сувиллын орчин нөхцлийг сайжруулах, ахмадыг ая тухтай амраах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор ахмадын Цагаан-Уул амралтын газрын 20 орыг шинэчилж 6 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн “Ахмадаа ачилъя” хөтөлбөрөөс гаргаж санхүүжүүллээ.	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх
Ерөнхийлөгчийн зарлиг							
13	74	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Албан хэргийг хос бичгээр хөтлөх туршилтын ажлыг эхлүүлээд байна. 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 41 дүгээр тушаалаар баталсан Гудамж, зам, талбай үл хөдлөх хөрөнгө, аж ахуй нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага, монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэл MNS:6395:2022 стандартыг хангасан 12 нэр төрлийн хэвлэмэл хуудаснаас сонгон авч захиалгаа Архивын Ерөнхий газарт хүргүүлэв. Мөн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 25 байгууллага, 17 сумын албан бланк хэвлэмэл хуудас бэлэн болсон байна. Хэлний үндэсний зөвлөл, Архивын Ерөнхий газар хамтран 11, 12 дугаар сард архив, бичиг хэргийн ажилчдад Монгол бичгийн сургалт, монгол бичгээр хэвлэмэл хуудас дээр хэрхэн бичиж, хэвлэх сургалтыг зохион байгууллаа. Аймгийн ИТХТ-ийн 2021 оны 59 дүгээр тогтоолоор “Монгол хэл бичиг”	100%	30%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх

				дэд хөтөлбөр батлагдаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 19 хүний бүрэлдэхүүнтэй аймгийн “Хэлний бодлогын салбар зөвлөл”, 17 сумын хэлний бодлогын салбар зөвлөлийг байгуулан ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд сумдын Засаг дарга нар, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нар, орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагад “Үндэсний бичиг үсгээ сурах, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай”, “Үндэсний бичиг соёлоо сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэхэд хамтран ажиллах тухай” албан бичгийг хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. ЕБС, СӨББ-аас хаягжуулалтыг гэрэлтдэг байдлаар хийсэн бөгөөд, орчин бүрдүүлсэн 42, дотор хаягжилт буюу 940 анги танхимын хаягийг мөн бүх сумдын Соёлын төвүүд гадна хаягаа монгол бичгээр бичиж, хаягжуулсан байна. Ховд хотын орох гарах замд байрлах самбарыг кирилл болон монгол бичгээр хослуулан бичиж байрлууллаа. Үндэснийхээ бичиг үсгийг сурах, хэрэглэж хэвшихийг уриалсан “Үндэсний бичиг өв соёлоороо бахархъя” цахим уриалгыг /challenge/ цахимаар түгээлээ. “ҮНЭТ ӨВ, ҮНДЭСНИЙ ДАРХЛАА-ЭХ ХЭЛ МИНЬ” аяныг зохион байгуулж 3500100 төгрөгийг зарцуулав.			
14	75	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104	1.16.. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих	Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/370 дугаар тушаалаар батлагдсан сургуулийн орчинд зарах хориотой бүтээгдэхүүний жагсаалтыг сургууль орчмын дэлгүүр худалдааны төвүүдэд албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Жаргалант сумын 6 сургуулийн орчимд 8 дэлгүүр үйл ажиллагаа явуулдаг ба бүх дэлгүүрт эцэг эхийн хяналтын зөвлөл болон, хүүхэд хамгааллын багаас хяналт	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх

				хийж зөвлөгөө өгсөн болно. Хөдөөгийн сумдын хувьд сургууль цэцэрлэгийн байршил төвдөө байдаг тул сургуулийн бүсэд бүх дэлгүүрүүд байрладаг асуудал зарлигийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлдөг ба “Зохистой хооллолт ба эрүүл мэнд” сарын аяныг зохион байгууллаа. Тус нөлөөллийн ажлын хүрээнд эрүүл мэндийн хичээлээр дамжуулан хоол, шим тэжээлийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор 24 сургуулийн 14870 сурагчдад сургалт зохион байгууллаа. Мөн 2022 онд эрүүл зөв хоол хүнс хэрэглэхийн ач тус сэдвээр сургуулийн эмч нар 14200 сурагчдад сургалт сурталчилгааны ажил хийсэн бөгөөд цаашид сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгох хичээл үйл ажиллагааны хүрээнд зөв зохистой хүнсний хэрэглээг сонгож сурах дадал хэвшлийг эзэмшүүлэх ажлыг тогтмол хийх шаардлага байсаар байна.			
15	76	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын	Цаг агаарт үүлэнд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны зардалд байгаль хамгаалах сангаас 15 сая төгрөгний санхүүжилтийг 2022 онд шийдвэрлүүлсэн ба УЦУОШГ-ын даргын 2022 оны 05 дүгээр сарын 05-ны А/62 тоот тушаалаар цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаагаа эхлүүлж, “Ховд-Бороо--1” “Ховд-Бороо-2” гэсэн 2 экспедицийн инженер, техникч, мэргэжилтэн нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй ажиллав. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн V хуралдаанд өргөн барьж, 5/07 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн 2022 оны төсөв” “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 20.0 сая мод тарих хөтөлбөрт 340.0 сая төгрөг зарцуулахаар тусгасан байна. Хөдөөгийн 16 сум мод тариалахад зарцуулагдах төсөв, санхүүгийн	100%	30%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх

		дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах	асуудлаа эртнээс төлөвлөн шийдвэрлүүлсэн бөгөөд сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, албан байгууллага болон ард иргэд, малчидтайгаа хамтран ажлын төлөвлөгөө гаргах зөвлөмж, чиглэл хүргүүлж ажилласны үр дүнд 17 сум тус бүр Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаараа сум 5.0-20.0 сая төгрөгийн төсөв, нийт 160.0 гаруй сая төгрөг батлуулж, 2022 оны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байна.			
	77	1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох	Аймгийн хэмжээнд хавар, намрын мод тарилтаар 292 аж ахуйн нэгж, байгууллагын 8819 иргэн, 175,136 мод, бут сөөг тариалж, 446,108,700 төгрөгийг зарцууллаа. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/166 дугаар тушаалаар ойн хөтөлбөрийн хүрээнд Ховд аймгийн Чандмань суманд 10 га, Мөст суманд 10 га, нийт 20 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулав. Сумдад 1.5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулах жишиг зураг гаргаж, сумдын Засаг дарга нарт хүлээлгэн өглөө. Бүх нийтийн мод тарих өдрүүдээр иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагуудад мод тарихыг уриалж, мод үржүүлгийн “Үр жимс” болон “Ховд сафари” хоршооноос сургалт, сурталчилгаа зохион байгуулсан байна. Намрын мод тарилтаар “Хашаандаа сайхан амьдаръя” төслөөс 10000 модны суулгацыг айл өрхүүдэд нийлүүлсэн байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй "ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөнийг орон нутагт эрчимжүүлэх зорилгоор намрын мод тарих сарын аяныг "ӨРХ БҮР ХАШААНДАА 10 Ш МОД ТАРЬЯ-2022" стандартын тарьц, суулгацын үзэсгэлэн худалдааг 10 дугаар сарын 14,15-ны өдрүүдэд “Ард-Аюуш”-ийн талбайд	100%	30%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх

			зохион байгуулж, иргэн аж ахуйн нэгж, байгууллагуудад мод тарьж ургуулахтай холбогдох мэргэжил арга зүйн зөвлөгөөг 50 гаруй иргэнд өглөө.			
78	1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах	Сум дундын Ойн анги, БОАЖГ-ууд Мод үржүүлгийн талбайд гүний худаг гаргахаар төлөвлөж байна. 2022 онд Улаан богочийн рашаан, Дарви сумын Мөрөн багийн цагаан давааны булгийг тохижуулж хамгаалатанд авлаа. Мөн аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газар, Үенч Бодонч Булган голын сав газрын захиргаа, сумдын Байгаль орчны алба, ГИДЦГ-ын ХЗ-тай хамтран, Усны нөөцийг хамгаалах, хомсдож бохирдохоос сэргийлэх зорилгоор Алтай сумын Алтангадас багийн нутаг болох Шангийн булаг, Бодонч багийн Хөндлөнгийн Шаварын булаг, Барлаг багийн Шил усны булаг, Элсэн ус, Сухайтын усны булаг, Булган сумын Байтаг багийн нутагт орших Бүдүүний усны булаг, Баян-Өлгий аймгийн Булган сумын Улаанхус багийн зуслангийн бүс нутаг болох Хөшөөн нуурууны булаг, Үенч сумын Улиаст багийн Цагаан эргийн рашааны эх, Хулстайн булаг нийт 9 булгийн эхийг томоохон ус ашиглагч МоЭнКо ХХК, Талст Молор ХХК, ОУ Тахь групп болон орон нутгийн санхүүжилтээр хашиж хамгаалсан байна.	100%	30%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх	
79	1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот	Сумдад 1.5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулах жишиг зураг гаргаж, сумдын Засаг дарга нарт хүлээлгэн өгсөн бөгөөд, жимс, жимсгэнэ тариалахад тохиромжтой Булган, Буянт, Жаргалант, Ховд сумдын нутагт шинээр 800 ширхэг бэсрэг алим, чавга (слив)-ны мод тариалж, Булган сумын жимсний гурван аж ахуй Улаанбаатар хот, Дархан, Эрдэнэт болон бусад аймгуудад 2000 ширхэг алим, жимсний суулгац худалдан	70%	30%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх	

		байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх	борлуулсан байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй "ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөнийг орон нутагт эрчимжүүлэх зорилгоор намрын мод тарих сарын аяныг "ӨРХ БҮР ХАШААНДАА 10 Ш МОД ТАРЬЯ-2022" стандартын тарьц, суулгацын үзэсгэлэн худалдааг 10 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд “Ард-Аюуш”-ийн талбайд зохион байгуулж, иргэн аж ахуйн нэгж, байгууллагуудад мод тарьж ургуулахтай холбогдох мэргэжил арга зүйн зөвлөгөөг 50 гаруй иргэнд өглөө. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63, 2021 оны 58 дугаар зарлигийн дагуу бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд Жаргалант сумын иргэд, аж ахуй нэгж, байгууллагууд Буянт гол, хорихын урд засмал зам дугуух 2 байрлалд хотынхоо өнгө үзэмж нэмж мод, бут сөөг тарилаа. Энэхүү үйл ажиллагааг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг бөгөөд энэ жил хоёр голын дунд 7000 мод, засмал зам дагууд 550 мод тарьж хамгаалалтын ойн зурвас байгууллаа.			
	80	2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй "ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөнийг орон нутагт эрчимжүүлэх зорилгоор намрын мод тарих сарын аяныг "ӨРХ БҮР ХАШААНДАА 10 Ш МОД ТАРЬЯ-2022" стандартын тарьц, суулгацын үзэсгэлэн худалдааг 10 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд “Ард-Аюуш”-ийн талбайд зохион байгуулж, иргэн аж ахуйн нэгж, байгууллагуудад мод тарьж ургуулахтай холбогдох мэргэжил арга зүйн зөвлөгөөг 50 гаруй иргэнд өглөө. "Ховд аймгийн газар тариалан эрхлэгчид, идэвхтэн байгаль хамгаалагчид, ойн чиглэлийн аж ахуй эрхлэгчдийн нэгдсэн чуулган” зохион байгуулж, чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Байгаль орчин,	100%	30%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх

				аялал жуулчлалын дэд сайд Г.Түвдэндорж, Ерөнхийлөгчийн байгаль орчны зөвлөх, доктор Н.Батхүү, байгаль орчны гавьяат ажилтан Д.Цэндсүрэн, Б.Лхамжав, гавьяат механикжуулагч И.Төлөөгөн, Ховд аймгийн Булган сумын иргэн Монгол Улсын аварга тариаланч С.Бааст, Ховд их сургууль, Политехник коллежийн удирдлага, оюутан залуучуудын төлөөлөл 300 гаруй хүн оролцон санал, сэтгэгдлээ нээлттэй илэрхийлэв. Намрын мод тарилтаар “Хашаандаа сайхан амьдаръя” төслөөс 10000 модны суулгацыг айл өрхүүдэд нийлүүлсэн байна			
16	81	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	1.3. Архи, согтууруулах ундаанд ногдуулах онцгой албан татварын орлогоос хавдрын эмнэлэг, донтох өвчнийг эмчлэх төв болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг байгуулах, архи согтууруулах ундааны хор уршгийг нийгэмд сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх чиглэлд зарцуулах;	Архи, согтууруулах ундаанд ногдуулах онцгой албан татварын орлого улсын төсөвт төвлөрч байгаа тул орон нутагт зарцуулах боломжгүй ба манай аймагт одоогийн байдлаар архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага байхгүй болно.	Х.Б	Х.Б	
	82		1.4. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох;	Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/579 дүгээр захирамжаар Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой этгээдээс зохион байгуулж буй бүх төрлийн баяр, ёслолын арга хэмжээ, ажлын байр, албан томилолтоор ажиллах үедээ архи согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон бөгөөд, архигүй, эрүүл, аюулгүй орчинд амьдрах дадал хэвшлийг иргэд, айл өрх, аж ахуй нэгжүүдэд сурталчлах, иргэд, хүүхэд, залуучуудыг чөлөөт	100%	100%	

			цагаа спортоор хичээллэх нөхцөл боломжийг хангаж ажиллахыг сум, байгууллагын дарга нарт үүрэг болгож, “Архигүй Ховд” аяны хүрээнд архи, тамхигүй, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах, эрүүл амьдралын хэв маяг дадал зуршлыг төлөвшүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд манлайлан оролцохыг иргэн, аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагад уриалга гарган ажиллаж байна.			
83	1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах;	Илүүдэл жингүй –Эртэч Монгол аяны хүрээнд нийт 211000 гаруй иргэн идэвхтэй дасгал хөдөлгөөнд хамрагдаж улсад тэргүүн байранд шалгарсан байна. Арга хэмжээнд 16 сумын 111500 иргэн 3 сарын турш тогтмол дасгал хийж хэвшсэн. 68 албан байгууллагын 100500 ажилтан албан хаагчид өглөөний дасгал ажлын байрны дасгалуудыг тогтмол хийж хэвшсэн байна. Идэвхтэй оролцсон байгууллага хамт олныг шалгаруулж эхнийг 5 байранд 5 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олголоо Спортын холбоодтой хамтран ажиллаж аймгийн Засаг даргын дэргэдэх шигшээ багт тоног төхөөрөмж байр танхимаар хангах ажлын төлөвлөгөөний дагуу Спортын аварга хөтөлбөрөөс боксын иж бүрэн стандарт рингийг 43 сая төгрөгөөр авч өглөө. Мөн таеквондогийн Сүлд-Алдар клуб, байт харвааны Залуурт сум холбооны тамирчдад бэлтгэл хийх заал танхимаар хангаж хамтран ажиллаж байна. Дээрх асуудлуудыг шийдвэрлэснээр шинэ хөгжиж байгаа спортын төрлүүдэд хичээллэх хүүхдийн тоо 10 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Мөн аймгийн хэмжээнд 2022 онд 4 шинэ спорт заалыг шинээр барьж, ашиглалтанд оруулсан байна.	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх	

	84		2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай.	Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/579 дүгээр захирамжаар Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой этгээдээс зохион байгуулж буй бүх төрийн баяр, ёслолын арга хэмжээ, ажлын байр, албан томилолтоор ажиллах үедээ архи согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон бөгөөд, архигүй, эрүүл, аюулгүй орчинд амьдрах дадал хэвшлийг иргэд, айл өрх, аж ахуй нэгжүүдэд суртачилах, иргэд, хүүхэд, залуучуудыг чөлөөт цагаа спортоор хичээллэх нөхцөл боломжийг хангаж ажиллахыг сум, байгууллагын дарга нарт үүрэг болгож, “Архигүй Ховд” аяны хүрээнд архи, тамхигүй, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах, эрүүл амьдралын хэв маяг дадал зуршлыг төлөвшүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд манлайлан оролцохыг иргэн, аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагад уриалан ажиллаж байна. Ховд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Цагдаагийн газар хамтран согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор архигүй бол зөрчилгүй уриан дор “Үггүй- Үйлдэл” нөлөөллийн аяныг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс 06 угаар сарын 25-ны хооронд зохион байгуулав. Аяны хүрээнд 5 төрлийн шторк, 11 төрлийн 1800 ширхэг зурагт хуудсыг бэлтгэж, цагдаагийн газрын пэйж хуудаст байршуулж, нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулав. Мөн “Хөдөөний айл” төрийн бус байгууллагын тэргүүн Ч.Ерөөлтүвшинг урьж “Эрүүл амьдралын хэв маяг”, “Архины хор уршиг” сэдэвт лекцэд 150 иргэнийг хамруулав. “Архигүй бол зөрчилгүй” гэрэл зургийн уралдааныг зохион байгуулж эхний 3 байр шалгаруулж, гэрэл зургийн үзэсгэлэн гаргасан нийт	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх
--	----	--	---	--	------	-----	---------------------------

				14 сургалт, 2 арга хэмжээнд 4152 иргэнийг хамрууллаа. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Ховд аймгийн Жаргалант сумын архины хамааралтай 2 иргэнийг сайн дурын эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, хяналт тавин ажилласан байна.			
17	85	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159	2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай.	Аймгийн ерөнхий боловсролын 25 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 33 цэцэрлэг, Хөгжил политехник коллеж, МУИС-ийн Ховд дахь салбар сургууль, Насан туршийн боловсролын 2 төв Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсан бөгөөд манай аймгийн сургалтын бүх байгууллагууд болон сумдын ЗДТГ төрийн бусад байгууллагууд энэхүү зарлигийг бүрэн хэрэгжүүллээ.	70%	70%	
	86		3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай.	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн үзэж дээдлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	70%	70%	
	87		4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай.	Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг төрийн болон төрийн бус байгууллага, иргэд аж ахуй нэгжүүдэд уриалан, албан байгууллага, айл өрхүүд Эзэн Богд Чингис хааны иш хөргийг залсан байна.	70%	70%	

ҮАБЗ-ийн зөвлөмж							
18	88	Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай 2010-03-18 Дугаар 2010_10/09	1. Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх,	Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Жаргалант сумын Цамбагарав багт байрлах 1 дүгээр цэцэрлэгийн 2659 метр квадрат барилга, Жаргалант сумын Цамбагарав багт байрлах “Шим ус” ОНӨААТҮГ-ын конторын барилга 208 метр квадрат барилга, Жаргалант сумын Наран багт байрлах Хот тохижуулах газрын 4417 метр квадрат барилга, Жаргалант сумын Цамбагарав багт байрлах Шүүхийн шийдвэрийн барилга, Жаргалант сумын Рашаант багт байрлах 36 айлын орон сууцны 3 барилга, Жаргалант сумын Магсаржав багт байрлах 16 айлын орон сууцны барилга, Жаргалант сумын Магсаржав багт байрлах 24 айлын орон сууцны 2 барилгуудыг тус тус дахин төлөвлөлтөнд оруулж, газрын төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.	100%	30%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх
	89		3. Газар хөдлөлтийн аюул, гамшигтай тэмцэх мэдлэг чадвар, дадал эзэмшүүлэх иргэний хамгаалалтын сургалт, дадлагыг улсын хэмжээнд байнга, тогтмол давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг нь тооцдог байх,	Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангаж, Ховд аймгийн хэмжээнд “Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийг 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр, “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургууль”-ийг 03 дугаар сарын 24-ний өдөр тус тус зохион байгууллаа. Ховд аймгийн хэмжээнд 578 аж ахуй нэгж байгууллага, 56237 хүн, 581 техник хэрэгсэл, 24 дуут дохио ажиллаж, гамшгаас хамгаалах мэргэжлийн алба 44, мэргэжлийн анги 39, нийт 1598 бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлаа шалгууллаа. Байгууллагын цахим болон	70%	30%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх

				фэйсбүүк хуудсанд арга хэмжээтэй холбоотой мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг, шторк, иргэдэд зориулсан зөвлөмж, сурталчилгааг бэлтгэн байршуулж олон нийтэд байнга сурталчлан ажиллаж байна.			
19	90	Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай 2017-01-10 Дугаар 2017_03/03	3.1. Аймаг, нийслэлийн ИТХ-ын хуралдаанаар орон нутгийн орчны бохирдлын асуудлыг хэлэлцэн холбогдох арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	“Агаар, орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр”-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж, тус хөтөлбөрийн хүрээнд 2019-2023 онд нийт 32 үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Ховд аймгийн УЦУОШТ-ын орчны чанарын хяналт-шинжилгээний лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор РМ-10, РМ-2.5 тоосонцрын агууламжийг тодорхойлох автомат тоосонцорын DUST TRAK-т багажийг 2022 онд авахаар тендер зарлаж Монтех дистрибьюшн ХХК шалгарч, ажлыг гүйцэтгэлээ. Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Ховд аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/727 тоот захирамжаар агаар бохирдуулагчийн эх үүсвэрийн нэгдсэн тооллого явуулах 15 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан бохирдлыг тооллогыг 2022 оны 03 дугаар сарын 15-ний өдөр хүртэл цахим системд илгээж, цаасан тайланг Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүргүүлэв. Жаргалант сум, Дуут, Эрдэнэбүрэн, Дөргөн, Мянгад, Чандмань, Зэрэг, Дарви, Цэцэг, Алтай, Үенч, Мөнххайрхан, Ховд, Манхан сумд нь төвлөрсөн дулааны 15 станцтай болоод байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас аймгуудын “Агаарын чанарын бүс тогтоох” аргачлалын сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр цахимаар зохион байгуулав. Агаарын чанарын бүсийг 2022 ондоо багтаан орон нутагтаа зохион байгуулах чиглэлийг	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх

				Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас өглөө. Ховд аймгийн Жаргалант, Буянт багуудад агаарын чанарын бүсийг тогтоох ажлын хэсгийг аймгийн Засаг даргын А/72 тоот захирамжаар байгуулан ажиллаж байна. 2022 онд “Их буян зах” Польш улсад үйлдвэрлэсэн утаа бага гаргадаг нам даралтын зуух суурилуулсан бөгөөд 2022-2023 онд аймгийн Засаг дарга гэр хорооллын айл өрхүүдэд ШУА-аас туршиж буй утааны шүүлтүүртэй янданг 5130 айл суурилуулах ажлыг судалж байна.			
20	91	Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40	2.4. Томоохон голууд дээр усыг хуримтлуулан урсацын тохируулга хийх. усан сан байгуулах, нийт нутгийн хэмжээнд хур тундасны усыг тогтоон барих далан, шингээх худаг, нэвчүүлэн цөөрөм барих ажлыг эрчимжүүлэх замаар усны нөөцийгш нэмэгдүүлж,и хүн ам болон эдийн засгийн салбаруудыг баталгаатай, хүрэлцээтэй усаар хангах нөхцөлийг бүрдүүлэх	Дэлхийн байгаль хамгаалах сангийн санхүүжилтээр Буянт гол дагуу 10 цэгт хяналтын камер байршуулж, зөрчлийг газар дээр нь илрүүлж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна. Ховд аймгийн Булган Байтаг багийн Бүдүүн харгайт, Нарийн Харгайт, Хужирт, Бүдүүний ус, Дамжигийн ус Улиастын голуудын хамгаалалтын бүсэд нийт 7 ширхэг тэмдэгжүүлэлт хийсэн. 2022 онд Улаан богочийн рашаан, Дарви сумын Мөрөн багийн цагаан давааны булгийг тохижуулж хамгаалатанд авлаа. Мөн аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газар, Үенч Бодонч Булган голын сав газрын захиргаа, сумдын Байгаль орчны алба, ГИДЦГ-ын ХЗ-тай хамтран, Усны нөөцийг хамгаалах, хомсдож бохирдохоос сэргийлэх зорилгоор Алтай сумын Алтангадас багийн нутаг болох Шангийн булаг, Бодонч багийн Хөндлөнгийн Шаварын булаг, Барлаг багийн Шил усны булаг, Элсэн ус, Сухайтын усны булаг, Булган сумын Байтаг багийн нутагт орших Бүдүүний усны булаг, Баян-Өлгий аймгийн Булган сумын Улаанхус багийн зуслангийн бүс нутаг болох Хөшөөн нуурууны булаг, Үенч сумын Улиаст багийн Цагаан эргийн рашааны эх, Хулстайн булаг нийт 9 булгийн эхийг томоохон ус ашиглагч МоЭнКо	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх

			ХХК, Талст Молор ХХК, ОУ Тахь групп болон орон нутгийн санхүүжилтээр хашиж хамгаалсан байна. Монгол оны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” /адапт/ төслийн захиалгаар Престиж инженеринг ХХК-ийн захирал Н.Ганзориг, мэргэжилтэн Б.Цэрэндаваа, Монгол улсын усны зөвлөх инженер Доктор Даваа нар Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргаатай хамтран Булган сумын Баянгол багийн Цахир үзүүр, Үенч сумын Улиастын ам, Байтаг багийн Хужирт, Бүдүүн харгайтын голын адагт хөв, цөөрөм байгуулах боломжтой голуудын усны өнгөрөлтөд физик, химийн хэмжилтүүд хийж судалгаа гаргасан байна.			
92		2.6. УБ хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гэр хороолол, аймаг сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий хэсэгчилсэн, зардал багатай ариун цэврийн байгууламжуудын шийдлийг туршин нэвтрүүлж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх	Шим-Ус ОНӨҮГ-тай хамтран аймгийн төвлөрсөн усан хангамжийн хайгуул хийж, нөөцийг тогтоох, бохир усыг цэвэрлэх, эргүүлэн ашиглах технологийг судлан төлөвлөгөө гарган ажиллаж бйгаа бөгөөд, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Hydrodesign innovation ХХК-аар зураг төсвийг боловсруулж, экспертизээр оруулах шатандаа явагдаж байна. Ховд аймгийн Жаргалант, Зэрэг, Алтай, Мянгад сумдад ажиллаж байгаа цэвэрлэх байгууламжууд цэвэрлэгээний түвшин хангалтгүй, шинэчлэл, засвар үйлчилгээ хийх шаардлагатай байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 150 аж ахуй нэгжийн хаягдал усны дүгнэлтийг Хар нуур-Ховд голын сав газрын захиргаа гаргаж хяналт шалгалтын ажлыг хамтран зохион байгуулж байна.	70%	70%	
93		2.7. Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвлүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зохистой	Шим-Ус ОНӨҮГ-тай хамтран аймгийн төвлөрсөн усан хангамжийн хайгуул хийж, нөөцийг тогтоох, бохир усыг цэвэрлэх, эргүүлэн ашиглах технологийг	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх

		менежментийг явуулах, үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж дахин ашиглахыг бодлогоор дэмжих	судалж төлөвлөгөө гарган ажиллаж байгаа бөгөөд, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Hydrodesign innovation ХХК-аар зураг төсөв боловсруулж, экспертизээр оруулах шатандаа явагдаж байна. “Дусал ус шижир алт” аяны хүрээнд Шим-Ус ОНӨҮТГ, Ховд аймгийн Жаргалант сумын орон сууцны айл өрхүүдэд хагас жилийн байдлаар 50 ширхэг цэвэр усны тоолуур суурилуулав. Ус хангамжийн эх үүсвэрийн 17 ундны усны худгуудыг ухаалаг системд шилжүүлж, цэвэр усны хамгамжийн хүртээмжийг нэмэгдүүллээ. Шим Ус ОНӨААТҮГ-ын цэвэр ус олзворлох гүний худгуудын ойролцоох 3 цооног дээр суурилуулсан газрын доорх усны хяналт шинжилгээний автомат төхөөрөмжөөс сар бүрийн 25-нд мэдээлэл татан авч газрын доорх усны улсын нэгдсэн сүлжээ WWW.GROUNDWATER.MN сайтад байршуулан ажиллаж байна.			
	94	2.11. Хо, суурин газрын үерийн хамгаалалтын далан, ус зайлуулах системийн найдвартай ажиллагааг хангах	Жаргалант сумын үерийн хамгаалалтын 1.4 км далан сэргээх, 3.7 км үерийн шуудуунд цемент бетон чигжээстэй чулуун бэхэлгээ хийх, харуулын 4х6 м харьцаатай байр барих зэрэг ажлын тендерт “Урбан девелопмент консалтинг групп” ХХК шалгарч, 2021, 2022 онд гүйцэтгэхээр байсан боловч 2,1 км шороон даланг сэргээх, 4х6 хэмжээтэй харуулын байрны барилгын ажлыг гүйцэтгэн эхний санхүүжилтээр 100,0 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэж, тус ажлыг хүлээн авсан байна. Тус ажил нь нийт 400,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай бөгөөд үлдэгдэл ажлын хөрөнгө оруулалтыг 2023 онд оруулахаар төсөвт тусгасан тул гүйцэтгэгчийн ирүүлсэн хүсэлтийн дагуу ажил гүйцэтгэх гэрээг цуцлаад байна. Мөн “Хаан ус тэнгис” ХХК-ийн хийсэн Ховд хотын үерийн хамгаалалтын байгууламжийн ажлын	70%	70%	

				16,505,968,917 төгрөгийн зураг төсөв хийгдэж хүлээн авлаа. Булган суманд Харганатын усны боолтыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж газар тариалангийн бүс нутгийг хамгаалсан байна.			
21	95	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар аваж зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар 2021_03	3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” хөдөлгөөн орон даяар өрнөж байна. Энэхүү хөдөлгөөнд нэгдэхийн тулд иргэд, аж ахуй нэгжүүд мод, бут сөөг тарих аргад суралцах нь чухал бөгөөд стандартын дагуу нүхээ ухаж, суулгацаа суулгаж, технологийн дагуу тарьц, суулгацыг үржүүлж, арчилснаар ажлын үр дүн гарна. Иймд аймгийн хэмжээнд мод, бут сөөг тарих сонирхолтой иргэдийг мэдээллээр хангах сургалтыг Алтай, Булган, Үенч, Мөнххайрхан, Дөргөн, Ховд, Жаргалант суманд зохион байгуулж, мод, бут сөөг тарих, суулгах, үржүүлэх, арчлахтай холбоотой сургалтанд 214 хүнийг хамрууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 1000 сургагч багш бэлтгэх сургалтыг аймагтаа зохион байгуулав. Ховд аймгийн 17 сумаас 51 хүн хамрагдаж онолын хичээлийг цахим болон танхимаар сурсан байна. Дээрх хөдөлгөөний хүрээнд нэгдсэн журмаар хоёр үе шаттай онолын сургалтыг цахимаар 5 дугаар сард 10 хоног, хээрийн дадлага сургалтыг 9 дүгээр сарын 21-25-нд Жаргалант сумын төвд 5 хоногийн хугацаатай зохион байгууллаа. Улсын хэмжээнд сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг БОАЖЯ, БШУЯ, МУИС, ШУТИС, ХААИС хамтран зохион байгуулж байна. Тус аймагт МУИС-ийн Ойн хүрээлэнгийн захирал Н.Баатарбилэг, МУИС-ийн доктор профессор Д.Суран нар дадлага ажлыг удирдан чиглүүлж, аймгийн БОАЖГ, Сум дундын Ойн ангитай хамтран сургалтыг үр дүнтэй зохион байгууллаа. Ховд	100%	30%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх

				аймгийн 17 сумаас сургалтад оролцож, сургагч багш нар сум орон нутагтаа мод тарих ажлыг сурталчилах, соён гэрээрүүлэх, мод тарьж арчлан ургуулах, тарьц, суулгацын нөөцийг бүрдүүлэх, түүнчлэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад мод тарих мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч манайлан ажиллах юм. Байгаль орчноо хайрлан хамгаалах зөв дадал, боловсролыг сурагчдад олгох сургуулийн соёл болгох зорилгоор Эко сургууль, тогтвортой хөгжлийн боловсролын арга зүйг 24 сургууль, 7 цэцэрлэгт нэвтрүүлсэн бөгөөд Боловсрол шинжлэх ухааны 6 мэргэжилтэн тогтвортой хөгжлийн боловсролын орон нутгийн сургагч багшар бэлтгэгдэв.			
ЗГ-ын тогтоол							
22	96	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_204	9. Автомашины хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогдуулан жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт	Автомашины хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэн, орон тоо багасгасантай холбоотой жолооч нарт ажлаас халагдсаны тэтгэмж, олговрыг олгон чөлөөлсөн бөгөөд зарим жолоочийг шилжүүлэн ажиллуулсан байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү аж ахуйн тасгийн жолооч Ө.Энхтайван нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу ажлаас чөлөөлөгдсөн тул үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 3 сарын тэтгэмж олгож чөлөөлсөн байна. Мөн бусад сумд болон байгууллагуудын тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлсэн, шилжүүлсэн болон хэрэглээг хязгаарласантай холбоотой жолооч нарын ажлын байрны асуудлыг шийдвэрлэхээр түр хүлээлтийн байдалтай байна.	70%	70%	

			авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.				
23	97	Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-09 Дугаар 2022_402	1.3. цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч ашиглалтад оруулсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор баригдаагүй бөгөөд энэ талаар холбогдох тушаал шийдвэр зөрчин хариуцлага хүлээсэн албан тушаалтайн байхгүй болно.	100%	100%	
	98		1.4. орон сууцны хороолол, цогцолбор барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэг байгуулах зорилгоор түрээслэх, худалдан авах, салбар бүлэг ажиллуулахад норм нормативыг мөрдүүлэх чиглэлээр мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг авч, хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Ховд аймгийн Жаргалант сумын хэмжээнд хувийн 8 цэцэрлэг байгаа бөгөөд бүгд орон сууцны болон хувийн байрны нэгдүгээр давхарт байрлаж, сургалт үйл ажиллагаагаа зохион байгуулж байна. Бүх хувийн цэцэрлэгүүд нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргаж, зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа явуулж байгаа ба тайлант хугацаанд шинээр цэцэрлэгийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хүсэлт ирээгүй болно.	100%	100%	

	99		2. Цаашид шинээр баригдах орон сууцны хороолол, цогцолбор барилга байгууламжийн зураг төсөлд цэцэрлэг төлөвлөх, ашиглалтад оруулах талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллахыг дор дурдсан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай: 2.1. барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг заавал тусган баталгаажуулж байхад хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 2.2. орон сууцны хороолол, цогцолбор барилгад төлөвлөгдсөн цэцэрлэгийн барилгыг бүрэн ашиглалтад орох хүртэл хугацаанд тухайн бүс нутгийн байршилд “түр цэцэрлэг” байгуулан ажиллуулж байх талаар хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	2022 онд шинэ суурьшлийн бүсэд 75 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг, малчны хороололд сургууль, цэцэрлэгийн цогцолборыг шинээр барьж эхлүүлээд байна. Цаашид орон сууцны хороолол шинээр нэмэгдэж хүн амын нягтрал ихсэж байгаатай холбогдуулан барилга нь хуучирч, ашиглах боломжгүй болсон барилга байгууламжийг шинэчлэх, өргөтгөх арга хэмжээг үе шаттайгаар шийдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна.	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх
--	----	--	---	--	------	-----	---------------------------

24	100		3. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан цэцэрлэгийн барилгыг тусгасан эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Ховд хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу аймгийн төвөөс 4.2 км зайд байрлах, дэд бүтэц бүрэн шийдэгдсэн, 245 га газар бүхий шинэ суурьшлын бүсэд орон сууцны барилга, үйлчилгээний төв, таун хаус, амины орон сууцны зориулалтаар хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгэсэн бөгөөд зураг төслийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 75 хүүхдийн цэцэрлэг баригдаж байна.	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх
	101		4. Цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр түрээслэх, худалдан авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх, шаардагдах зардлыг жил бүрийн улс, нийслэл, орон нутгийн төсвийн төсөлд тусгахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Манай аймгийн хэмжээнд цэцэрлэг, сургуулийн хүртээмж боломжийн бөгөөд хэт ачаалалтай биш сургууль 2 ээлжээр хичээллэж байгаа тул одоогийн байдлаар сургууль, цэцэрлэгийн байр худалдан авах болон түрээслэх шаардлага гараагүй ба мөн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилгыг түрээслүүлэх болон худалдан борлуулахаар санал, хүсэлт ирээгүй бөгөөд 2020-2021 онд Жаргалант сумын 7 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан болно.	100%	100%	
	102	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23	3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. /2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших	"Алсын хараа 2050" урт хугацааны бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх хүрээнд хот, хөдөөгийн сэргэлтийг хангах, Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг дэмжих цогц арга хэмжээний санал боловсруулах, ажлын хэсэгт өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх үүрэг бүхий аймгийн Засаг даргын орлогч Т.Дэлгэрсайханаар ахлуулсан дэд ажлын хэсгийг Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 28-	100%	70%	

	Дугаар 2022_419	иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай./	ны өдрийн А/684 дүгээр захирамжаар байгуулан ажиллаж байна. Дэд ажлын хэсэг 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар “Нээлттэй Ховд аймаг” дэд хөтөлбөрийн төслийг хэлэлцэж байгууллага тус бүрээс Улаанбаатар хот болон төв суурин газраас ирж суурьших аж ахуйн нэгж, иргэдэд үзүүлэх үйлчилгээ, давуу талыг хөтөлбөрт тусгахаар шийдвэрлэлээ. “Улаанбаатар хотоос Ховд аймагт шилжин суурьших иргэд аж ахуй нэгж байгууллагыг дэмжих арга хэмжээний санал боловсруулах” хэлэлцүүлэгийг 2023 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр Нутгийн удирдлагын ордны хуралдааны Их танхимд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, аймгийн ИТХ-ын дарга Г.Пүрэвганди, аймгийн Засаг дарга Э.Болормаа, ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баярсүх, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, Засаг даргын орлогч, хэлтсийн дарга, байгууллагын удирдлагууд нийт 80 хүн оролцож “Нээлттэй Ховд аймаг” хөтөлбөр, аймаг, орон нутагт шилжин ирж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих” дэд ажлын хэсгийн 2023-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг боловсруулж, хөтөлбөрийн төслийг аймгийн ИТХ-ын даргад өргөн барив. Аймгийн 2023 оны төсөвт Шинэ сэргэлт төрийнн бүтээмж-цахимжуултад 320.0 сая төгрөг, Шинэ сэргэлт-шилжилт хөдөлгөөнд 479.2 сая төгрөг, Тэрбум мод үндэсний хөтөлбөрт 350.0 сая төгрөг, Шинэ Ховд Үйлдвэрлэл, инноваци, технологи нэвтэрүүлэлтэд 294.0 сая төгрөг тус тус баталсан байна.			
	103	4. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой	Хот, хөдөөгийн сэргэлтийг хангах дэд ажлын хэсэг 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар “Нээлттэй Ховд аймаг” дэд хөтөлбөрийн төслийг	70%	0%	Бодит үр дүнг нэмэгдүүлж

			тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	хэлэлцэж, хөтөлбөрийн төслийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад өргөн барив. Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд боомтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 2022 оны 7 дугаар сарын 21-ний өдөр Ховд аймаг, БНХАУ-ын Цонж Хуй өөртөө Засах аймагтай Байтаг-Улиастай боомтыг нээх тухай цахим хурал зохион байгуулж, Байтаг -Улиастай боомтыг байнгын ажиллагаатай болгох, Байтаг боомтоос Булган сум хүртлэх 120 км хатуу хучилттай авто зам барих талаар зөвшилцөж, тус тусын дээд шатны байгууллагад уламжлахаар болов. Аймгийн Засаг дарга Э.Болормаа БНХАУ-ын Алтай аймгийн Засаг дарга Жейнс Хаддист боомтын үйл ажиллагааг эрчимжүүлэх, хоёр аймгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар цахим хурал хийж, хуучин боомтыг зорчигч тээврийн гарц хэвээр нь ажиллуулж, хилийн 126-127-р тэмдэгтэд Булган-Такешикен боомтын нүүрс тээврийн шинэ гарц нээх тухай нэгдсэн ойлголтод хүрэв. Мөн аймаг, орон нутагт хэрэгжих хилийн боомтын хүрээнд Булган боомтыг өргөтгөн нэвтэрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, Байтаг боомтын ажиллах хугацааг нэмэгдүүлэх, эрчим хүчний хувьд 90 мватын хүчин чадалтай Эрдэнэбүрэний УЦС-ийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг хангаж төсөлд дэмжлэг үзүүлэх, баруун 3 сумыг 35 кватын өндөр хүчдэлийн дамжуулах шугамыг ашиглалтанд оруулах, аж үйлдвэрийн хувьд үйлдвэр технологийн болон агро паркийн ажлыг эрчимжүүлэх, ерөнхий төлөвлөгөөг хийж батлуулах, утаагүй түлшний үйлдвэрийг барьж ашиглалтанд оруулах, жилийн 300.0 мянган тоннын хүчин чадалтай, цементний үйлдвэрийг ашиглалтанд оруулах, зэрэг хөгжлийн томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг төлөвлөгөөндөө			шуурхай ажиллах
--	--	--	--	---	--	--	------------------------

				тусгалаа. Дээрх ажлуудыг хэрэгжүүлсэний үр дүнд манай аймагт бизнес эрхлэх таатай орчин бүрдэж, ажлын байр нэмэгдэх, хүн амын тогтвор суурьшилтай амьдрах ажиллах нөхцөл бүрдэж, хотоос хөдөө шилжин суурьших иргэдийг татах боломж бүрдэх юм.			
25	104	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448	1.12. . 1.12 гүйцэтгэсэн ажлын бүтээмжийг нь харгалзан аймаг, сумын засаг захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг хоёр дахин хүртэл нэмэгдүүлсэн хэмжээгээр тооцож, орон нутгийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан олгох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.13.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.14.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аймаг болон сумын	Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор нутгийн захиргааны байгууллагын төрийн захиргааны албан хаагчдын цалинг шатлалгүй болгон дээд шатлалаар, мөн ЗГ-ын 488 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосны дагуу цалингийн сангийн төсвийг төлөвлөж, төсвийн байгууллагуудын төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн төсвөөс 30 хувийн нэмэгдлийг олгохоор төсөвт тусган батлууллаа. Аймаг, нийслэлээс сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд орлого хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг тооцох аргачлал”-ыг баримтлан нийт хуваарилагдах хөрөнгийн 50-аас доошгүй хувь / 8780,6/-ийг сумын ОНХС-д хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамааруулан хуваарилав. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан тухайн аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Хөшөөтийн уурхайн МоЭнКо компанийн орон нутагт өгсөн хандив, тусламжийг ОНХС-д бүртгэж, ил тод, нээлттэй болгох замаар тус хуулийн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэнд	100%	100%	

		орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.15.нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэнд жилийн 3 хувийн хүүтэй ипотекийн зээл олгох, орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжийн арилжааны банкнаас авсан зээлийн хүүг 1 хувь хүртэл бууруулж олгох ажилд орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.16.нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид бизнесээ эрхлэхэд нь зориулж газар болон холбогдох тусгай зөвшөөрөл олгох арга хэмжээг хүнд сурталгүйгээр шуурхай шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.17.гадаад зээлийн хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг Монгол Улсын 2023 оны төсөвт тусгасан дүнгээр	орон нутгийн зүгээс үзүүлэх дэмжлэгийг хууль журмын дагуу үзүүлж байна. Нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид бизнесээ эрхлэхэд нь зориулж газар болон холбогдох тусгай зөвшөөрөл олгохыг хууль журмын дагуу холбогдох байгууллагуудад хүргүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээ авч байна. Дамжуулан зээлдүүлсэн зээлээс 2022 онд үндсэн зээл 928.4 сая, хүү 323.2 нийт 1251,6 сая төгрөгийг аймгийн төсөвт орох ААН-ийн орлогын албан татварын 40.0 хувийн орлогын давсан хэсгээс суутгуулан бүрэн төлөв.			
--	--	---	---	--	--	--

		бүрэн төлж барагдуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;				
105		2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд нийт 26,7 тэрбум төгрөгийг Төрийн хэмнэлтийн тухай хуулинд нийцүүлэн төлөвлөж, шийдвэр гаргасан баримт бичгийг үндэслэн холбогдох арга хэмжээ, төслийн хэрэгжилтийн онцлог, үе шатны ажлын гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжилтийг олгохоор тооцож байна. Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй, нэмэлт гэрээ хийгээгүй бөгөөд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 174 төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж 102 төслийг ашиглалтад хүлээн авсан ба Засгийн газрын 2022 оны 495 дугаар тогтоолын дагуу 16 төсөл, арга хэмжээг барьцаа дансанд байршуулсан байна. Мөн он дамжин хэрэгжих 56 төсөл, арга хэмжээ байна. УИХ-ын 88 дугаар тогтоолын дагуу үнийн өсөлтөөр төсөв нэмэгдсэн 14 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Үүний хүрээнд Сангийн яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу ажлын хэсэг байгуулан, шийвэр гаргаж, 4 төслийн гэрээг байгуулан 2 төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохоор Сангийн яаманд хүргүүлээд байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжсэн 34 төсөл арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр	100%	100%	

			батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS- www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах.	дамжуулан хэрэгжүүлж, нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллалаа.			
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
26	106	2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2021-11-03	XII.6.5. Аймаг, нийслэлийн хэмжээнд иргэдийг нүүлгэн шилжүүлэх түр байрыг томилгоожуулж, шаардлагатай материал хэрэгслээр хангах, нөөц бүрдүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймгийн хэмжээнд нүүлгэн шилжүүлэлтийг 23 цэгт зохион байгуулахаар төлөвлөлт хийж, тэмдэг, тэмдэглэгээг байрлуулж аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгасан байна.	70%	30%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх
	107	Дугаар 2021_58	XII.6.7. Булган, Говь-Алтай, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймгийн төвүүдийн нутаг	Ховд аймгийн төвийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг шинэчлэх судалгааны ажлын зардал 2018-2019 оны улсын төсөвт батлагдсан байна. Газар хөдлөлийн бичил мужлалын зураг	Х.Б	0%	Шуурхай зохион байгуулах

27			дэвсгэрийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг зохиох арга хэмжээ авахыг Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч Д.Рэгдэлд;	хийгдээгүй Булган, Говь-Алтай, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл гэсэн 9 аймагт уг ажил эхлээд байсан ч санхүүжилтийн улмаас зогсонги байдалд орсон бөгөөд гэрээний хугацааг 2019 оны 10 дугаар сарын 04- ны өдөр, 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр тус тус сунгасан байна. Засгийн газрын хуралдааны шийдвэрийн дараа БХБЯ-аас Хөвсгөл аймгийн төв Мөрөн, Өмнөговь аймгийн төв Даланзадгад сумын газар хөдлөлийн бичил мужлалын ажлыг 2022 онд хийж дуусгах, үлдсэн аймгуудын газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг 2023-2024 онд хийж дуусгахаар тохиролцон гэрээг сунгасан бөгөөд гэрээний дагуу санхүүжилт тус хүрээлэнд орж ирээгүй байна.			
	108		XII.6.8. Дээр дурдсан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож, улс, орон нутгийн жил бүрийн төсвийн төсөлд тусгах, гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Дээрх арга хэмжээнд зориулж ШУА-ийн Одон орон, геофизикийн хүрээлэн нь БХБЯ-ны захиалгаар “Аймаг, сум, суурингуудын нутаг дэвсгэрийн газар хөдлөлийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгаа” зөвлөх үйлчилгээний гэрээт ажлыг 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн Дугаар №2018/175 тоот гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Орон нутгаас дахин хөрөнгө оруулалт хийх, тендер зарлах боломжгүй юм.	Х.Б	0%	Шуурхай зохион байгуулах
	109	2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11	XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах	Цахим Ховд” дэд хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-ын нэг болох төрийн	100%	100%	

		дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11	шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав.	бүтээмжийг нэмэгдүүлэх, шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, “Нэг цонхны үйлчилгээ”, “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийг 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн операторын хэлбэрээр үйлчилгээ үзүүлдэг “Үйлчилгээний нэгдсэн төв” болгосноор төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулан, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чухал үр дүнгээ өгсөн ажил болж, орон зайнаас үл хамааран аль ч сумын иргэн тус төвөөр үйлчлүүлж, төрийн үйлчилгээг нэг дороос авах боломж бүрдлээ. Тус төвд 6 байгууллагын 10 мэргэжилтэн байнга ажиллаж, 2022 оны 12 дугаар сарын байдлаар 8000 иргэнд 37 төрлийн үйлчилгээг нэг дороос түргэн шуурхай хүргэж, 17 сумын операторуудаар дамжуулан иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж, 2570 иргэнд 54 төрлийн лавлагаа, мэдээлэл олгосон байна. Нэгдсэн төвийн ахлах мэргэжилтэн, Сүлжээний мэргэжилтэн, Угтах үйлчилгээний оператор гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаж байгаа бөгөөд өдөрт 80-110 иргэн нэгдсэн төвөөр үйлчлүүлж байна. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, “И-Монгол” улсын төсөвт үйлдвэрийн газрын хамтарсан баг 2022 оны 5 дугаар сарын 20-27-ны өдрүүдэд Ховд аймагт ажиллаж, “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем”-ээр дамжуулан нутгийн захиргааны байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлдэг 100 орчим нэр төрлийн олон шатлалт үйлчилгээг цахимаар хэрхэн авах талаар орон нутгийн иргэдэд заавар, зөвлөмж өгөх, сургагч багш бэлтгэх зорилгоор “Иргэдэд мэдээллийн технологийн ур			
--	--	---	---	--	--	--	--

				чадварыг олгох” сургалт зохион байгуулж, Жаргалант сумын 600 гаруй иргэд хамрагдав.			
28	110	2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2022-04-20 Дугаар 2022_24	ХИҮ.8.3. Хот, суурин газруудын хөгжлийн чиг хандлагыг харгалзан газрын тухай хууль тогтоомжид заасан хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газрын тэг гортигийг шинэчлэх асуудлыг судлан зохих арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох төслөөс санхүүжүүлэн "Лапланд эко" ХХК, "Тэгш хэм групп" ХХК-ийн боловсруулж буй Зэрэг, Мянгад, Эрдэнэбүрэн, Алтай, Үенч, Дуут, Мөнххайрхан, Манхан, Дөргөн, Ховд сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд суурин газрын тэг гортигийг шинэчлэх асуудлыг тусган батлуулахаар ажиллаж байна. Төлөвлөгөө боловсруулах ажил хээрийн судалгаа хийгдэж, боловсруулалтын шатандаа хэрэгжиж байна.	70%	70%	
	111		ХИҮ.8.4. Архангай, Говь-Алтай, Ховд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх ажлыг 2022 онд багтаах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг тус аймгийн Засаг дарга нарт.	Аймгийн ерөнхий төлөвлөгөөг хийлгүүлэхэд шаардлагатай төсөв, ажлын даалгаврын төслийг боловсруулан аймгийн ИТХ-д хүргүүлж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10 дугаар хуралдаанаар орон нутгийн 2023 оны төсөвт 153,9 сая төгрөг, Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох төслөөс 70 хувь буюу 359,1 сая төгрөгийг төсөвт суулгасан байна.	70%	70%	
29	112	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28	ХХ.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9	Аймгийн хэмжээнд өнөөдрийн байдлаар 18100 иргэнд буюу 30 хувьд нь иргэний цахим үнэмлэхний санах ойд нь буюу гар утасны аппликейшнийг ашиглан цахим гарын үсэг суулгаж өглөө. Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч нар аймгийн Зэвсэгт хүчний 123 дугаар анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх “Нээлттэй хаалттай” хорих анги, Онцгой байдлын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Цаг уур орчны шинжилгээний	70%	70%	

		дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.	газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Жаргалант сумын өрхийн эмнэлгүүд, Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн багш ажилчдад болон 11,12 дугаар ангийн 16-аас дээш насны сурагчдад тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгууллаа. Улсын Их Хурлын гишүүн ЗТХ-ийн яамны сайд С.Бямбацогтын ажлын албанаас зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгөөр Дарви, Чандмань, Зэрэг, Манхан, Эрдэнэбүрэн, Мөст, Ховд, Буянт сумдад очиж улсын бүртгэгч нартай хамтран 1100 гаруй иргэдэд тоон гарын үсэг олгож ,улсын бүртгэлийн байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажлуудын талаар, Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам, Цахим гарын үсгийн тухай хуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийн талаар мэдээлэл өглөө. Шинэ оны босгон дээр тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх үүднээс Аймгийн музей, Шим ус үйлдвэрийн газар, Худалдан авах ажиллагааны хэлтсийн нийт 54 ажилтан албан хаагчдад “Тоон гарын үсгийг хэрхэн олгох, хэрэглээндээ хэрхэн ашиглах, хэрэглэх талаар мэдээлэл өгч тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгууллаа. ГХБХБГ, МХГ, НДХ, ТХ, УБХ, ХХҮГ, ОНӨГ зэрэг аймгийн төрийн байгууллагууд тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүллээ. Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран сургалтууд зохион байгуулж 400 гаруй төрийн албан хаагчдыг хамруулсан бөгөөд бөгөөд мөн “Иргэдэд тоон гарын үсэг олгох нь” сэдэвт сургалтад сумдын ЗДТГ-ын 38 албан хаагч хамрагдаж, сургагч багшаар бэлтгэгдэж байна.			
--	--	--	---	--	--	--

30	113	2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2022-06-22 Дугаар 2022_34	XII.10. . Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа геологийн судалгааны ажлын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт даалгав: 1. Геологийн салбарыг тэргүүн ээлжид хөгжүүлэх стратегийн бодлогыг баримталж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг төрийн удирдлагаар хангаж хот, суурин газар, бүс нутгийн хэмжээнд геоэкологи, газрын доорх ус, газар хөдлөл, хөрсний гулсалтын геологи орчинг тодорхойлох, эрдэс баялгийн салбарт дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах тааламжтай орчинг бүрдүүлэх, олборлох салбарыг ашигт малтмалын найдвартай нөөцөөр хангах зорилгоор улсын төсвийн санхүүжилтээр өөрийн аймгийн нутаг дэвсгэрт гүйцэтгэж байгаа бүх төрлийн геологийн судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх; 2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдтай байгуулсан “Хамтран	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ховд аймаг дахь дэд зөвлөл байгуулан ажиллаж байна. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Булган, Үенч сумдад “Геологийн судалгааны төв” ТӨҮГ “Торлог Уул-50” төслийн хүрээнд, Эрдэнэбүрэн, Дөргөн, Ховд, Буянт, Мянгад, Дуут, Манхан, Чандмань, Зэрэг, Дарви сумдад “Судалт Мана” ХХК болон МУИС-ийн хамтарсан түншлэлийн баг, Дуут, Чандмань, Мөнххайрхан, Зэрэг, Булган, Үенч, Мөст, Цэцэг сумдад “Ховд 2020” төслийн хүрээнд “Геосан” ХХК тус тус геологийн судалгааг хийж байгаа ба хуульд заагдсан бүрэн эрхийн хүрээнд хариуцсан орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлэн ажиллах чиглэл хүргүүлэн ажиллаж байна. Дээрх гурван судалгааны ажилд ямар нэгэн хүндрэл гараагүй хэвийн явагдаж байна. Газрын доорхи усны чанар стандартын судалгааны хүрээнд Ховд аймгийн 17 сумын төвийн ундны усны 64 эх үүсвэрийг усны чанарын стандартад нийцсэн эсэхийг тодорхойлсон бөгөөд шинжилгээний дүнгээс 58 усны эх үүсвэр болох гүний худгуудыг нарийвчлан авч үзэхэд хэрэглэх боломжгүй 1 худаг, шүүлтүүр тавих шаардлагатай 13 худаг, халдваргүйжүүлэлт хийх шаардлагатай 11 худаг, хэвийн 33 худаг хэвийн гэсэн дүгнэлт гарсан.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Буянт сумын Цагаан эрэг багийн Улаан товгор, Дөргөн сумын Сээр багийн Дээд мэнгэ, Ховд сумын Цагаан бургас багийн, Шар нүдэн, Мянгад сумын Чацарганат багийн, Хашаат, Дөргөн сумын Сээр багийн Аравжуулын Бөгч, Мянгад сумын Цагаан булан багийн Булуун 6 худгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Алтайн Хар сувд ХХК хийж гүйцэтгэж байна.Дуут, Мөнххайрхан, Дарви, Зэрэг, Манхан	70%	70%	
----	-----	---	--	--	-----	-----	--

			ажиллах гэрээ"-ний дагуу тухайн судалгааны ажлын үр дүнг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах; 3. Аймаг, сумын Засаг даргын тамгын газраас төсөл хэрэгжүүлэгч тухайн аж ахуйн нэгж, байгууллагатай хамтарч улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа судалгааны ажлын зорилго, үр дүнгийн талаар орон нутгийн иргэдэд таниулах, сурталчлах арга хэмжээг жил тутам зохион байгуулж байх.	сумын Гурван замын бэлчир 5 худгийг Эвлэл ХХК хийж гүйцэтгэж байна.			
31	114	2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл 2022-08-17 Дугаар 2022_41	ҮIII.6. . “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцыг 2022 оны хагас жилийн байдлаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох агентлагийн дарга нарт тус тус даалгав: 1.1. Удирдлага, зохион байгуулалтаас шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байгаа	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажлуудаас эрчимжүүлэх шаардлагатай доорхи ажлуудад анхаарлаа хандуулан ажиллах шаардлагатай. Үүнд: ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, аймгийн төвд түрээсийн орон сууц барих, гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартад нийцүүлэх, бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжих, аймгийн төвөөс алслагдсан сумдад ажиллаж, амьдарч байгаа төрийн албан хаагчдын ажиллаж, амьдрах таатай орчныг бүрдүүлэх хүрээнд албаны орон сууцаар хангах ажлыг зохион байгуулах зэрэг юм. “Саруул цамхаг” ХХК-ны гүйцэтгэж байгаа ХАА-н гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламжийн барилгын ажил 80 хувьтай, ажлын гүйцэтгэл зогссон бөгөөд, тоног төхөөрөмжийн угсралтын ажилд шаардагдах 2,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт улсын төсөвт	70%	70%	

			зорилт, арга хэмжээг жилийн эцсийн зорилтот түвшинд хүргэх; 1.2. Санхүү, хөрөнгийн эх үүсвэрээс шалтгаалан эхлээгүй байгаа төсөл, арга хэмжээг улсын төсвөөс гадна гадаадын зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах замаар хэрэгжүүлэх боломжийг судлан, шийдвэрлэх; 1.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлэх; 1.4. Улсын Их Хуралд энэ онд өргөн мэдүүлэхээр төлөвлөсөн хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар нэн даруй хэлэлцүүлж, өргөн мэдүүлэх.	төсөвлөгдөхгүй байгаагийн улмаас уг байгууламж ашиглалтанд орохгүй гүйцэтгэл дутуу байна. Цаашид Бүсчилсэн хөгжлийн бодлого, шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, Булган боомтын өргөтгөл, Хог хаягдлын үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын барилга угсралтын ажил, Хүнсний ногооны зоорь, өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангах дэд бүтцийн өргөтгөл, шинэчлэл, 4С олон улсын нисэх буудал, тээвэр логиستيкийн төв байгуулах, ариутгах татуурга, шугам сүлжээний өргөтгөл, Зооноз өвчин судлалын төвийн барилга, зэрэг төслүүдийн Зураг төсөв, ТЭЗҮ хийгдэж байгаа, хийгдсэн ба хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй байна. Тухайн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх саналаа Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам болон гадаадын зээл, тусламж, Олон улсын байгууллагуудад хүргүүлэв. Дээрх ажлуудын гүйцэтгэлийг эрчимжүүлэх талаар онцгой анхаарч, хөрөнгө оруулалтыг татах боломжийг судлан ажиллаж байгаа ба 2023 оны 01 дүгээр сард Инвест Ховд хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт зохион байгуулж, хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр ажиллах юм.			
32	115	2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл	ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл	Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт баригдахаар тусгагдсан “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг байгуулж, 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдөр 12 их эмч, 13 сувилагч, тусгай мэргэжилтэн нийт 25 хүний бүтэц орон тоотойгоор байгуулж ажиллуулсанаар эрт	70%	70%	

		2022-08-24 Дугаар 2022_42	ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	илрүүлгийн үзлэгийг хийхэд ихээхэн үр дүнгээ өгч байна. 2022 оны байдлаар эрт илрүүлэх үзлэг шинжилгээ оношилгоонд 0-17 насны 12311 хүүхдийг, 18-аас дээш насны 4007 хүн, нийт 16318 иргэдийг эрт илрүүлэг үзлэгт хамруулж, 19.76 хувийн гүйцэтгэлтэй байна. Мөн тус төвөөр төр, хувийн хэвшлийн 31 албан байгууллагын 2510 ажилтан, албан хаагч, ерөнхий боловсролын сургуулийн 1703 сурагч нийт 4213 хүнийг, Оюутны эрүүл мэндийг дэмжих сараар 480 оюутныг үзлэгт хамруулж, “Нутгийн намар” арга хэмжээг сумдад зохион байгуулж 4477 иргэд, нийт 20370 иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулсан байна.			
33	116	2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр 48 дугаар тэмдэглэл 2022-10-05 Дугаар 2022_48	XII.3.2.4. Зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх арга хэмжээ авч, 2022 оны 10 дугаар сард багтаан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад	2022 онд батлагдсан Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ нь 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөх бөгөөд үүнтэй холбогдуулан “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2022 оны УИХ-ын 35 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх талаарх саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн болно. Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлд зааснаар аймаг орон нутагт Байгаль орчны чиглэлээр 9 тусгай зөвшөөрөл, 8 энгийн зөвшөөрөл,	100%	100%	

			хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, төрийн болон нутгийн захиргааны байгууллагад.	Барилга хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр 14 тусгай зөвшөөрөл, 1 энгийн зөвшөөрөл, Соёл, боловсролын чиглэлээр 3 тусгай зөвшөөрөл, Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр 3 тусгай зөвшөөрөл, Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар 1 тусгай зөвшөөрөл, 1 энгийн зөвшөөрөл, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр 2 тусгай зөвшөөрөл, 1 энгийн зөвшөөрөл, Эрүүл мэндийн чиглэлээр 10 тусгай зөвшөөрөл, Эрчим хүчний чиглэлээр 11 тусгай зөвшөөрөл, Зам тээврийн хөгжлийн чиглэлээр 2 энгийн зөвшөөрөл буюу нийт 53 тусгай зөвшөөрөл, 13 энгийн зөвшөөрлийг тус тус олгохоор заасан байна. Аймгийн хэмжээнд зөвшөөрөл олгож буй үйл ажиллагаанд аливаа зөрчил, дутагдал илрээгүй бөгөөд хууль, журмын дагуу зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулж байгаа болно. Зөвшөөрлийн тухай хуулиар олгогдох тусгай болон энгийн зөвшөөрлийг нэгтгэсэн, хассан, шилжүүлсэн, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн харъяалал өөрчлөгдсөнтэй холбогдуулан зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа нутгийн захиргаанаас гаргасан шийдвэрийг энэ хуульд нийцүүлэхээр холбогдох арга хэмжээг авч шийдвэрлэхээр санал боловсруулан ажиллаж байгаа болно.			
34	117	2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54	Х.11.2. “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг байгууллагын үйл ажиллагаанд уялдуулан зохион байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллахыг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан	Туршилтын шатандаа байгаа бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс бүрэн ашиглалтад оруулж, хэрэглээнд нэвтрүүлэх талаар хамтран ажиллаж байна.	Х.Б	Х.Б	

		тушаалтныг харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч нарт;				
118		Х.12.2. “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж төрийн өмчийн бүх шатны боловсролын сургалтын байгууллагын болон шинжлэх ухааны байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч, дүнг танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Боловсролын мэдээллийн системд 24 сургууль, 2 насан туршын боловсролын төв, 33 цэцэрлэгийн газрын бүртгэлийг хянан, газар эзэмших гэрчилгээг файлаар хавсарган мэдээллийг оруулав. Ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн эзэмшил газарт өөр барилга байгууламж барьсан талаар судалгаа авсан бөгөөд үүнд, Цэцэг сумын ерөнхий боловсролын сургуулийн эдэлбэр газарт сумын Засаг даргын 2008 оны 61 тоот захирамжаар сургуулийн талбай 4 га байсан боловч сумын Засаг даргын 2018 оны А/29 дугаар захирамжаар 1,7 га болж багасгасан ба сургуулийн эзэмшлийн газар болон барилгуудыг хувьчлан олон жил болж, олон эзэн дамжин өөрийн эзэмшил болгосон тул тэдгээрийг сургуулийн газраас хасав. Чандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн эзэмшил газарт "Таанын ембүү" аж ахуйн нэгж газрын зөвшөөрөлгүйгээр 169 м2 газарт дэлгүүрийн өргөтгөл, Чандмань эх булаг аж ахуйн нэгж газрын зөвшөөрөлгүйгээр 247 м2 дэлгүүрийн өргөтгөл баригдсан, Жаргалант сумын ЕБ-ын 3 дугаар сургуулийн эзэмшил газарт 16 дугаар дулаан дамжуулах төв баригдсан, Чандмань сумын цэцэрлэгийн эзэмшил газарт байх хуучин цэцэрлэгийн барилгад багийн контор, намын байр байрлаж, бусад өрөө тасалгаанууд нь хувь хүний эзэмшилд байгаа, Жаргалант сумын 4 дүгээр цэцэрлэгийн хашаанд хажуу айлын граж, цэцэрлэгийн газар луу 4 метр 30 см түрж орсон, Жаргалант сумын 7 дугаар цэцэрлэгийн Салбар цэцэрлэгийн хашаан дотор хувь хүний граж байрласан, мөн 2м 30 см өндөртэй, 6м урттай 3.5 м өргөнтэй төмөр байгууламж байна. Нийт 7	100%	100%	

				цэцэрлэг, сургуулийн эзэмшил газарт барилга байгууламж баригдсан зэрэг зөрчил байгааг илрүүлсэн байна.			
35	119	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.5. . Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан дүнгийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Отор нүүдлийн шилжилт, хөдөлгөөнийг мал эмнэлгийн үзлэгт хамрагдсан гарал үүслийн гэрчилгээг үндэслэх, тархвар зүйн асуумжийн дагуу зохион байгуулан ажиллах талаар аймаг, сумд хооронд гэрээ байгуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг бүх шатны Засаг дарга нарт;	2022 оны жилийн эцсээр нийт 3475,5 мянган мал /үүнээс тэмээ 29,5 мянга, адуу 149,4 мянга, үхэр 205,5 мянга, хонь 1244,1 мянга, ямаа 1846,9 мянга/ тоологдсон урьдчилсан дүн мэдээ гарсан. Нутгийн 70 гаруй хувьд цасан бүрхүүлтэй. Малчид өөрийн хэмжээнд өвс, тэжээлээ бэлтгэсэн боловч цас их байгаагаас зарим сумдад цагаан зудын нөхцөл байдалтай байна. 2022 оны 11 дүгээр сарын 21-нээс баруун 3 сум буюу Алтай, Булган, Үенч сумдад цас орж 30-80 см, хунгарласан газартаа 120 см хүрч өвөлжилт хүндрэх нөхцөл байдал үүслээ. Тухайн үед сумдын ЗДТГ, Онцгой байдлын алба, хэлтэс шуурхай ажиллаж цасанд боогдсон малчдыг цас багатай баг болон сумын төв рүү нүүлгэх ажлыг зохион байгуулсан ба энэ үеэр Их улаан даваа, бага улаан даваа, Хавтаг, Байтагийн чиглэлийн зам даваа хаагдсаныг ОБГ-аас шуурхай арга хэмжээ авч хилийн цэрэг, Булган суманд дахь онцгой байдлын хэлтэс, ЗДТГ-аас хүн хүч, техник дайчлан нийт 17,0 сая төгрөгний түлш шатахуун зарцуулж нээсэн байна. Бусад сумд одоогоор өвөлжилт хэвийн байна. Чандмань сумаас Алтай суманд отроор явсан 5 өрх цасанд боогдсоныг сумын Засаг даргын Тамгын газраас шуурхай арга хэмжээ авч нүүлгэх ажлыг зохион байгуулсан байна. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 07-ний өдрийн 01 дугаар удирдамж, Мал эмнэлгийн газрын даргын 2022 оны 05 дугаар сарын А/39 дугаар тушаалын дагуу отор, нүүдлийн зориулалтаар Ховд аймгаас Дорнод, Төв, Баянхонгор, Сүхбаатар, Хэнтий, Говь-Алтай, Завхан, Улаанбаатар хот руу 175 гарал үүслийн	100%	100%	

				гэрчилгээг 1883 адуу, 890 үхэр, 10927 хонь, 11605 ямаа, 617 тэмээ, нийт 25922 малд олгож хяналт тавин ажиллав. Гадны аймаг сумаас адуу 378, үхэр 367, хонь 2253, ямаа 2674 толгойд отор нүүдлийн зориулалтаар 48 цахим гэрчилгээтэй 5672 толгой мал ирэн өвөлжиж байна. МЭЕГ-ын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/36 албан тоотод зааснаар аймаг, сум, багийн МЭҮЭ-ийн эмч нартай хамтран Бог малын мялзан өвчний шинж тэмдэгт суурилсан идэвхгүй тандалтыг 17 сумын 490 өрхөөс асуумж судалгаа авч, боловсруулалт хийж байна			
36	120	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	Аймгийн нийт 17 Сумдын Засаг даргын Тамгын газар, Соёлын төв, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, аймгийн төвийн төрийн болон орон нутгийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд зэрэг нийтдээ 110 гаруй байгууллагад албан бичиг солилцооны дундын системийг ашиглаж, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцон ажиллаж байна. Удахгүй албан бичгийн системд цахим гарын үсэг ашиглах талаар төлөвлөж, эрх бүхий албан тушаалтнуудад цахим гарын үсгийг олгох талаар ажиллаж байна.	100%	70%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх